

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НД ЗААСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ

№	Бүлэг, зорилт, арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд заасан бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт, шалтгаан нөхцөл	Монгол Улсын хөгжлийн 2022 оны бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах санал
1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого				
Зорилго 1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.				
1	1.1.1. Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлох, вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлох	95	Коронавируст халдвар (COVID-19)-ын судалгааг судалгааны тэргүүлэх 10 чиглэлийг батлуулж, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон. Монгол Улсад SARS-CoV-2 вирусийн гадаргуугийн S уургийн аминхүчлийн V143F, S640F өөрчлөлттэй шинэ хувилбар өвчлөл үүсгэсэн ба вирусийн генийн хувьсал үргэлжлэх хандлагатай байна гэжээ. Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн Дельта хувилбарын SARS-CoV-2 вирусийн геномыг судалсан судалгааны дүгнэлтэд Монгол Улсад SARS-CoV-2 вирусийн Дельтагийн 10 хувилбар зөвөөрлөгдөн орж ирсэн ба 4 хувилбар нь дотоодын халдвар үүсгэсэн. КОВИД-19 вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа, КОВИД-19 эсрэг вакцины гурав дахь сэргээх тунгийн дараах дархлааны хариу урвал болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн судалгааны үр дүн гарсансаар уг арга хэмжээний хэрэгжилт хангалттай байна.	Төсөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, гүйцэтгэлийн тайланд хүрэх түвшинд заасан арга хэмжээ бүрээр тайлагнах,
2	1.1.2. Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх	90	2022 онд КОВИД-19-ын эрсдэлийн үнэлгээг 1, сармагчны цэцэг өвчний эрсдэлийн үнэлгээг 3 удаа тус тус хийж, эрсдэлийг бууруулах зөвлөмж гарган хэрэгжүүлсэн байна. Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс бүрдүүлэхэд анхаарч, гадаад зээл тусламжийн хөрөнгөөр КОВАКС механизмын хүрээнд нийт 41.4 тэрбум төгрөгийн эм, хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлж ажиллажээ.	санхүүжилтийг төсвийн жилд зохицуулалт хийн шийдвэрлэсэн бол түүний хууль зүйн үндэслэлийг мэдээлэх, төсөвлөлтийн үндэслэлийг сайжруулах
3	1.1.3. Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах	0	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Дорнод аймгийн Хавирга, Увс аймгийн Боршоо, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, танилцуулга, санхүүжилтийн тооцоог хийж хүргүүлж төслийн Удирдах хорооны хурлаар дэмжигдсэн боловч АХБ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан 2023 онд нийлүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотой байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
2. Хүний хөгжлийн бодлого				
2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна				
4	2.1.11. Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх	90	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий 828 гаруй эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний цахим тогтолцоо нэвтрүүлсэн байна. Олон улсын “Эрүүл мэндийн үндэсний тооцооны систем-2011” аргачлалын дагуу үндсэн 9 ангиллаар тооцооллыг гаргаж тус ангиллаар санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаагаас тайлангууд нэгтгэлийн шатанд буюу бүрэн нэгтгэгдэж дуусаагүйтэй холбоотой байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
5	2.1.12. Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	90	Хамрагдалтын хувь 2022.11.15-ны байдлаар 93.0 хувьд хүрсэн нь тайлагналын хугацаа дуусаагүйтэй холбоотой байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
6	2.1.30. “Ковид-19” халдварт вирусийн эмчилгээнд нэн шаардлагатай уушги орлуулагч ЭКМО аппаратын тоог нэмэгдүүлэх	90	Уушги орлуулагч ЭЗМО аппарат өмнөх оноос 2 ширхэгээр нэмэгдэж иргэдэд тусламж үйлчилгээ байна. ЭКМО аппарат худалдан авах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.	Оновчтой төлөвлөх, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, санхүүжилтийг шийдвэрлэх
7	2.1.20. “Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах	80	“Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, иргэдийг урьдчилсан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулах талаар олон нийтэд сурталчлах ажлыг мэдээллийн сувгаар зохион байгуулахад анхаарч хамрагдалтыг нэмэгдүүлэхийг эрчимжүүлэх.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
8	2.1.8. Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх	70	Дэлхийн банкны санхүүжилтээр “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд нийт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд ашиглаж байгаа програм хангамжид хувийн эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг системд хадгалагдаж буй иргэний эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэсэн байна. Мөн Үндэсний дата төвд сервер тоног төхөөрөмжүүд байршуулан ЭМДЕГ-тай гэрээ бүхий лавлагаа шатлалын болон анхан шатны эмнэлэг, 50 гаруй хувийн эмнэлэг зэрэг эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээлэл солилцооны платформ системд холбож, нийт эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны платформыг нэвтрүүлсэн.	Төлөвлөлтийг сайжруулах
9	2.1.19. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх	70	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд 5 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 35.8 хувьтай байгаа тул цаашид эрчимжүүлэх шаардлагатай байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
10	2.1.22. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх	70	“Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 50.3 хувьтай байгаа тул цаашид эрчимжүүлэх шаардлагатай байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

11	2.1.23. Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангах	70	Улсын төсвийн санхүүжилтээр яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглах түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг болон лавлагаа шатлалын 6 эрүүл мэндийн байгууллагад 4.1 тэрбум төгрөгөөр, мөн түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгөөр нийт 5.1 тэрбум төгрөгөөр, Япон улсын Засгийн газраас Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний 2 дугаар төвд түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон 8 автомашиныг олгож тус тус ашиглалтад оруулсан байна. Мөн яаралтай тусламж үзүүлэх чадавхийг сайжруулах хүрээнд цахим болон танхимын сургалтад 21 аймаг, нийслэлийн 40 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан бөгөөд цаашид санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулалтыг эрчимжүүлэх.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
12	2.1.26. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	70	Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн ажилчдын цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоосноор эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдынхаа үндсэн цалинг 10-43 хувь хүртэл нэмэгдүүлж, 500.0 мянгаас 30.0 сая төгрөг хүртэлх урамшуулал олгож орон сууцны урьдчилгаа болон бусад асуудлаа шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Оновчтой төлөвлөх
13	2.1.31. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлыг хийх	70	Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлыг хийх ажлын хүрээнд 2022 онд Эрүүл мэндийн сайдын багцад 72,898.8 сая төгрөг батлагдсан байна. 90 хувийн гүйцэтгэлтэй 2 барилга, 62.8 хувийн гүйцэтгэлтэй 11 барилга, 26.2 хувийн гүйцэтгэлтэй 31 барилга, худалдан авах шатанд 5 барилга, гүйцэтгэгч шалгараагүй 1 барилга байгаа талаар тайланд ирүүлсэн байна. Барилгын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч шалгараагүйтэй холбоотой байна.	Оновчтой төлөвлөх, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
14	2.1.4. Геронтологийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хүргэх	50	Геронтологийн төвийн барилга царцсан, барилга угсралтын ажил хийгдээгүй бөгөөд барилга угсралтын ажлын зураг төсвийг Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдэл улсын төсөвт батлагдаагүйтэй холбоотой байна. Сэргээн засах төвийн барилгыг Геронтологийн төв болгохоор шийдвэрлэсэн бөгөөд /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, 36 ор/-ын ажлын явц 46.0 хувьтай байгаа.	Төлөвлөлтийг оновчтой болгох, санхүүжилтыг шийдвэрлэх
15	2.1.5. Орон нутагт яаралтай тусламжийн 10 цэг байгуулах	50	Осол, гэмтэл ихээр гардаг цэг болох 10 аймгийн 10 суманд яаралтай тусламжийн жишиг цэг байгуулах арга хэмжээний хүрээнд ДЭМБ-ын санхүүжилтээр шаардлагатай тоног, төхөөрөмжийг худалдан авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан, тус цэгт ажиллах эмч, сувилагчдыг сургалтад хамруулж бэлтгэл ажлыг хангасан бөгөөд үйл ажиллагааг жигдрүүлэх, эмч ажилчдыг чадавхжуулахад анхаарах.	Төлөвлөлтийг оновчтой болгох, Санхүүжилтийг шийдвэрлэх
16	2.1.16. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэдэг болоход түүхий эдийг татвараас чөлөөлөх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	50	2022 оны 12 сарын байдлаар эмнэлгийн хэрэгслийн 17 хувийг дотоодод үйлдвэрлэсэн нь суурь түвшингээс 15.6 хувиар нэмэгдсэн бөгөөд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарах.	Боловсруулалтын шатны ажлыг хурдасгах
17	2.1.6. Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх	0	Барилгын зураг төсөв хийгдэж дуусаагүй, газрын асуудал шийдэгдээгүй, санхүүжилт батлагдаагүй байгаа учир уг арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
18	2.1.15. Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх	30	Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд ажиллах ажилчдыг сургах тоог нэмэгдүүлэх, тус программын талаарх ойлголт, хэрэглээ, дүгнэлт гаргах аргачлал, шинэчлэлийн талаар мэдээллийг бүрэн эзэмшүүлэх.	Төлөвлөлтийг оновчтой болгох, Санхүүжилтийг шийдвэрлэх, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
19	2.1.27. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах	30	ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолоор эрсдэлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу 2022 оны даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан нь зорилтот түвшингийн 35.0 хувьд хүрсэнээр уг Цаашид эрүүл мэндийн даатгалын санд төвлөрөх орлогыг нэмэгдүүлж, эрсдлийн сангийн хувь хэмжээг өргөх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
20	2.1.29. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох	30	Иймд эрүүл мэндийн байгууллагуудыг орчин үеийн нүхэн жорлон, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг зохион байгуулахыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ус, ариун цэврийн байгууламжийн судалгаа хийгдэж дууссан, зураг төсөв хийгдэж байгаа болон санхүүжилт батлагдсан тул ариун цэврийн байгууламжийг барих ажлыг эрчимжүүлэх.	Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажлыг бүрэн дуусгах
21	2.1.1. Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх	0	Санхүүжилт шийдэгдээгүй учир барилгын ажил эхлээгүй байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
22	2.1.2. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх	0	Санхүүжилт шийдэгдээгүй учир барилгын ажил эхлээгүй байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
23	2.1.3. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх	0	Барилгын ажил эхлэх санхүүжилтийн тодорхой хувийг улсын төсөвт тусгасан боловч тендерт шалгарсан "Хар чонот" ХХК ажил гүйцэтгэх эрхээ хязгаарлуулсан бөгөөд дахин тендер зарласан боловч шүүхийн маргаантай мөн санхүүжилтийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй учир ажил эхлээгүй байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
24	2.1.21. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний дельта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах	0	Элэгний D вирустай иргэдийг эмийн эмчилгээнд хамруулах зорилгоор D вирусын эсрэг Bulevirtide (Hepcludex) эмийг Хүний эмийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэр, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/347 дугаар тушаалаар 2 жилийн хугацаагаар өнчин эмийн жагсаалтад оруулсан боловч тус эмийг Монгол улс импортлон оруулж ирэхгүй байгаагаас тус ажил удаширч, арга хэмжээ хэрэгжээгүй байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
25	2.1.25. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх	0	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар-II барилгын зураг төсөв өмнөх онд хийгдсэн боловч барилгын ажлын санхүүжилт шийдэгдээгүй учир уг арга хэмжээ хэрэгжээгүй.	Санхүүжилтийг шийдвэрлэх
26	2.1.28. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах	0	Барилгын ажлын зураг, төсөв бүрэн дуусаагүй, барилгын санхүүжилт шийдэгдээгүйгээс уг арга хэмжээ хэрэгжээгүй байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
27	2.1.32. Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих	0	"Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл"-ийн зураг төсөв 40 хувийн гүйцэтгэлтэй, барилгын ажил эхлээгүй байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
2.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.				

28	2.2.2. Нийслэлийн усан бассейний бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлж, Баянзүрх, Налайх дүүргийн спортын цогцолборыг ашиглалтад оруулах	70	Налайх дүүргийн 700 хүний суудал бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажил 90 хувь, Баянзүрх дүүргийн спорт цогцолборын гүйцэтгэлийн ажил 70 хувь, нийслэлийн усан бассейний бүхий спорт цогцолбор гадна шугам сүлжээний зураг шинээр боловсруулах ажил 30 хувьтай тус тус хийгдэж байгаагаас уг арга хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
29	2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	0	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор барих төсөл"-ийн зураг төсөв, газар бэлэн болсон боловч санхүүжилт шийдэгдээгүй тул барилгын ажил эхлээгүй байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
2.3. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.				
30	2.3.6. Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэлээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлж, хос хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	90	Тус ажлын хүрээнд монгол хэлний 2-5 дугаар ангийн сурагчдад зориулсан гарын авлага, дасгал ажлын дэвтэр ("Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх)-ийг боловсруулан Баян-Өлгий аймгийн бага ангийн сурагчдын тоогоор хэвлэн түгээсэн, эх хэлээр боловсрол эзэмшээгүй Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын үндэстний цөөнхийн хүүхдүүд, иргэд (цаатан-тува)-д зориулсан эх хэл соёлын жишиг хөтөлбөр, гарын авлага боловсруулан сургалтад ашиглаж байгаагаас тус арга хэмжээний хэрэгжилт төсөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
31	2.3.8. Багш мэргэжлийн стандартыг батлуулж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	90	35 багш "Чанарын менторчлол" хөтөлбөрт хамруулсан БШУ-ны сайдын 2022 оны А/122 дугаар тушаалаар салбарын багш, зарим ажилтнуудын үндсэн цалингийн доод хэмжээг өмнөх сүлжээний 5 дугаар шатлалаар шинэчлэн тогтоож, салбарын хэмжээнд нийтлэг авдаг зарим нэмэгдлийг цалин хөлсний бүрэлдэхүүнд тусгасанаар багш нарт гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн санхүүжилт олгодог болсон байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
32	2.3.18. Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчлэх	90	2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд 35077, цэцэрлэгт 266024 хүүхэд хамрагдаж хоол тэдгээрт хоол, хүнсээр үйлчилсэн бөгөөд Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 498 тоот тогтоолоор Хоолны зардлын норматив-ыг шинэчлэн тогтоосноор уг арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
33	2.3.20. Зориулалтын хоол үйлдвэрлэлийн байргүй ерөнхий боловсролын 18 сургуульд шинээр өргөтгөл барих, 225 сургуулийг стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах	90	2022 онд нийслэлийн 6 дүүрэгт Баянгол дүүрэгт 10, 14 аймагт 28 нийт 38 сургуулийн барилга бүрэн ашиглалтад орж, зориулалтын хоол үйлдвэрлэлийн байртай болсон байна. 2022 онд улсын төсөв болон олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нийт 204 сургууль стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Үүний үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид аюулгүй орчинд эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр хангагдах нөхцөл бүрдсэнээр уг арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
34	2.3.1. Төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах	70	Уушиг орлуулагч ЭКМО аппаратаар 2022 оны 10 эхний 10 сарын байдлаар 30 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Тайлант хугацаанд 2 ЭКМО аппарат нэмж худалдан авч эмчилгээнд ашиглаж байгаа нь тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэнээр уг арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
35	2.3.3. Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	70	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийг үнэлэх, агуулгын хоцрогдлыг оношлох зорилгоор 2021 оны 10 дугаар сард суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн оношлох үнэлгээг хийж 2-12 дугаар ангийн суралцагчид түүврийн аргаар сонгогдон хамрагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх "Гүйцэтгэлийн үнэлгээ"-ний шалгалтыг бичгийн шалгалт, асуулгын хэлбэрээр 654 сургуулийн 30111 багш, давхардсан тоогоор 600000 орчим суралцагч, 350000 гаруй эцэг эх, асран хамгаалагч, 4000 орчим сургуулийн удирдах ажилтан хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтын оношлох үнэлгээний мөрөөр хоцрогдол арилгахад чиглэсэн олон арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
36	2.3.5. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах	70	Ерөнхий боловсролын 200 сургууль монгол бичгийн кабинетыг шинэчлэн байгуулах, сайжруулах зэргээр сургалтын орчныг бүрдүүлж, дунд, ахлах ангийн 33138 хүүхдийг шалгалтад хамруулж, 2390 багш нийт 8227 цахим хичээл, 15502 цахим хэрэглэгдэхүүн, 5315 контентыг боловсруулж, эх хэлний сургалтад ашигласанаар уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
37	2.3.10. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалтын орчныг бүрдүүлэхэд бүх шатны байгууллагад дэмжлэг үзүүлэх	70	Мөн БШУ-ны сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээнд тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамруулахад сургууль, цэцэрлэгт дэмжлэг үзүүлэх чиглэлээр арга хэмжээ тусгасны дагуу тодорхой үр дүнтэй ажлууд хийгдэж, орон нутгийн 80 гаруй сургууль, 90 гаруй цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэрэглэгдэхүүнийг нийлүүлж мөн Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
38	2.3.11. Сонгинохайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн барилгыг шинээр барих, ерөнхий боловсролын 25 болон 63 дугаар тусгай сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг эхлүүлэх	70	Улсын төсвийн 6,819.3 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сонгинохайрхан дүүрэгт баригдах 150 хүүхдийн ортой тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэнээр барилгын каркас угсрах ажил бүрэн хийгдэж, зоорины давхрын дулаалгын болон өрлөгийн бэлтгэл 40 хувьтай хийгдсэн байна. Улсын төсвийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүрэгт баригдах тусгай хэрэгцээт 230 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилгын тендер зарлагдаж, газар чөлөөлөлт хийгдэж байгаа мөн Чингэлтэй дүүрэгт баригдах тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга барих гэрээг барилгын ажил гүйцэтгэх компанитай байгуулан, газар чөлөөллөлтийг бүрэн хийж, зураг төслийн боловсруулалт 15 хувьтай байгаагаас уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

39	2.3.14. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын үндэсний төвийг шинэчлэн зохион байгуулж, боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгох	70	Боловсролын эрдэм шинжилгээ, сургалт, арга зүйн болон үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгох хүрээнд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Насан туршийн боловсролын үндэсний төвийг нэгтгэн Засгийн газрын 2021 оны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Боловсролын ерөнхий газар"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, үйл ажиллагааг нь 2022 оны 1 дүгээр сараас эхлүүлсэн байна. Агентлаг нь боловсролын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Засгийн газрын 2021 оны 407 дугаар тогтоолоор "Боловсролын хүрээлэн"-г "Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн" болгон өөрчлөн зохион байгуулж, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/10 дугаар тушаалаар баталсан байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
40	2.3.16. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдыг сургууль дээр ундны ус уух боломжийг бүрдүүлэх	70	44 сургуульд 50.0 сая төгрөгийн 144 ширхэг, 30 сургуульд 78.4 сая төгрөгийн 80 ширхэг ус шүүгч төхөөрөмжийг тус тус нийлүүлсэн. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 98 сургуульд 112.7 сая төгрөгийн 145 ширхэг ус шүүгч төхөөрөмж нийлүүлсэн. Энэхүү ажлын үр дүнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт ерөнхий боловсролын сургуулиудын 40 гаруй хувьд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан. Дорнод, Увс зэрэг аймгийн сумдын ерөнхий боловсролын сургуулиуд эцэг эхийн оролцоотойгоор суралцагчид сургууль дээрээ ундны ус уух боломжийг бүрдүүлсэн байна.	Ундны ус уух төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх
41	2.3.17. Цэцэрлэг, сургуулийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоож, хүн амын есөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан ерөнхий боловсролын 50 сургууль, 60 цэцэрлэгийг барьж ашиглалтад оруулах	70	2022 онд улсын төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд 40.0 тэрбум төгрөгөөр 24 ерөнхий боловсролын сургууль, 24.7 тэрбум төгрөгөөр 36 цэцэрлэг, 3.6 тэрбум төгрөгөөр 6 ерөнхий боловсролын сургуулийн спорт заал, 5.2 тэрбум төгрөгөөр 7 дотуур байр, 1.2 тэрбум төгрөгөөр 1 боловсролын байгууллага, мөн гадаад зээл тусламжийн санхүүжилтээр 2 сургууль, 2 цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсноор уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Сургууль, цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах, тоог нэмэгдүүлэхэд анхаарах
42	2.3.19. Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг шинэчлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангах	70	Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 498 тоот тогтоолоор Хоолны зардлын норматив-ыг шинэчлэн тогтоосон, 2022-2023 оны хичээлийн жилд бага ангийн 371480 сурагч үдийн хоол үйлчилгээнд хамрагдаж харин дунд ангийн сурагчдыг үдийн хоолны үйлчилгээнд шилжих хугацааг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин бүрдэх хүртэл үе шаттайгаар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Үдийн хоолны чанар хүртээжийг нэмэгдүүлэх
2.4. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.				
43	2.4.1. Судалгааны үр дүнд бий болсон бүтээлийг олон улсад бүртгүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн чанарыг нэмэгдүүлэх шинжлэх ухааны үйлчилгээг үзүүлж, шилдэг бүтээлийг урамшуулах	70	2022 онд нийт 4 мэдээллийн сангийн лицензийн төлбөрт 258.4 сая төгрөг төлсөн байна. Олон улсын эрдэм шинжилгээний цахим мэдээллийн санд Монголын судлаач, эрдэмтэн, багш нарын хандах хандалтын тоо өмнөх оноос 20 гаруй хувирсан нэмэгджээ. Гадаадаас Монголын эрдэмтдийн 7282 бүтээлээс 108572 удаагийн эшлэл авсанаар Н индекс 118-д хүрсэн байна. 2022 онд шилдэг 6 бүтээлийг шалгаруулж бүтээл тус бүрд 10.0 сая төгрөгийн урамшуулал олгожээ. Мөн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын гэрчилгээ 123 патент, шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон 35 технологи, 76 шинэ биет бүтээгдэхүүнийг баталгаажуулсан зэр ажлыг хийж хэрэгжүүлсэнээр уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Шилдэг бүтээлийн тоог болон тэдгээрт олгох урамшууллыг хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах
44	2.4.5. Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх	70	БШУЯ-аас хилийн чанадад нарийн мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа монголчуудын оюуны урсгалыг эргүүлэн татаж, Монгол Улсын эдийн засаг нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх зорилгоор Солонгос улсад 2 удаа, Франц улсад нэг удаа тухайн улсад сурч, ажиллаж, амьдарч буй эрдэмтэн судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Засгийн газрын 2022 онд шинжлэх ухааны ажилтны тоо 108-аар нэмэгдсэн. Ахисан түвшний буюу магистр, докторын сургалтад хамрагдаж байгаа эрдэм шинжилгээний ажилтны эрдэм шинжилгээний багц цагийн 50 хувийг ажилласан цагт нь тооцож хөнгөлөх тухай санамж бичгийг Шинжлэх ухааны академи, МУИС, ШУТИС хамтран байгуулж, хэрэгжүүлж эхэлсэн. Тухайн 2 сургуулийн ахисан түвшний сургуульд 130 гаруй докторант эрдэм шинжилгээний ажилтан байгаагаас шаардлага хангасан 17 докторант хөнгөлөлтөд хамрагдсан. Орон нутгийн түвшинд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр 4 аймагт "Шинжлэх ухаан, технологийг түгээн дэлгэрүүлэх аян" зохион байгуулсан. 2022 оны 9 дүгээр сард 21 аймаг, нийслэлийн	Эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, инновацын хүний нөөцийг бэлтгэх ажлыг зохион байгуулах.
45	2.4.3. Нээлттэй, нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулж салбар дундын судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлүүлэх	50	Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд 4.8 га талбай бүхий газарт 72,000 м.кв ашиглалтын талбайтай, оффис, лаборатори, музей, хэвлэх үйлдвэр, агуулах, спорт цогцолбортой шинжлэх ухаан, технологи, инновацын кластерийн 7 блок барилгын ажил үргэлжлэн явагдаж байна. Гүйцэтгэгчээр "Нутгийн буян" ХХК ажиллаж байгаа бөгөөд гэрээ байгуулснаас хойш 2020 онд 3.0 тэрбум, 2021 онд 24.0 тэрбум, 2022 онд 20.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. 2023 онд бүрэн ашиглалтад орсноор кластер/нэгдсэн цогцолбор/-ын барилгын 27,000 м.кв талбай бүхий лабораторийн 3 корпус бүрэн ашиглалтад орж, судалгаа хийх олон улсын стандарт шаардлага хангасан нэгдсэн сүлжээ лабораториудыг бүрэн хүчин чадлаар ашиглах нөхцөл хангагдана. 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчийн 7 их сургууль /МУИС, ШУТИС, АШУУИС, ХААИС, МУБИС, ҮБХИС, ХСИС/-ийн дэргэд 103 туршилт, судалгааны лаборатори шинжлэх ухааны салбар бүрээр судалгаа шинжилгээ, туршилтыг бүрэн хүчин чадлаар хийж байна.	Лабораторийн цогцолборын барилгыг барьж дуусгах
46	2.4.4. Шинжлэх ухаан, инновацын салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх	30	Засгийн газрын хуралдаанаар "Шинжлэх ухаан технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг санхүүжүүлэх журам"-ыг батлуулсанаар үр дүнд суурилсан санхүүжилтийг олгох, өрсөлдөөнт санхүүжилт бүхий судалгааны судалгааны дэмжлэг авах нөхцөл бүрджээ. Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь 0.11 хувьд хүрсэн нь зорилтот түвшингээс 79.7 хувиар бага байгаагаас уг арга хэмжээний хэрэгжилт 30 хувьтай бөгөөд эрчимжүүлэх шаардлагатай байна.	Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийг нэмэгдүүлэх
2.5. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.				

47	2.5.2. Ажилтныг бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалтыг бий болгох	70	Ажлын бүтэн бус цагаар ажиллах ажилтны долоо хоногт ажиллах цаг 32-оос илүүгүй байх бөгөөд бүтэн бус цагаар ажиллах ажилтан нь бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин нөхцөлөөр хангуулах, цалингийн нэгжийн үнэлгээ ижил ажлын байранд бүтэн цагаар ажилладаг ажилтныхаас багагүй байх, ажилласан хугацаанд тохирсон ээлжийн амралт, нэмэгдэл хөлс авахаар заасан. Уртын ээлжийн хувьд ажиллах, амрах дээд доод хязгаарыг зааж, энэ хооронд ажилтан, ажил олгогч харилцан тохиролцох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр ажил, амралтын горим, уртын ээлжээр ажилласны нэмэгдэл зэргийг тогтоох боломжийг олгосон байна. Гэрээс, зайнаас ажиллах, иргэд хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулах шинэ зохицуулалт тусгагдсанаар уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Зайнаас ажиллах нөхцөл, боломжийг судлан хэрэгжүүлэх
48	2.5.8. Орлого багатай өрхийн гишүүдийг мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэх	50	Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийг баталсан бөгөөд 2022 онд 4 ээлжээр 21 аймаг 9 дүүргийн 1218 оролцогч тус төсөлд хамрагдаж ХЭДС-аас 2,931.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Тайланд сургалтад хамрагдагсдын хэдэн хувийг ажилд зуучилсан талаар дурдаагүй бөгөөд сургалтад хамрагдалт зорилтот түвшингийн 50 хувьтай тэнцэж байгаа зэргээс уг арга хэмжээний хэрэгжилт 50 хувьтай гэж дүгнэхээр байна.	Тайланд арга хэмжээний зорилтын хэрэгжилтийг тодорхой тайлагнаж байх
49	2.5.1. Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	30	Засгийн газраас Нийгмийн даатгалын багц хууль 2021 оны 10 дугаар сарын 15-ны Улсын Их Хуралд өдөр өргөн барьсан бөгөөд УИХ дахь олонхын бүлгээс "Хуримталын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ" гэсэн бодлоготой уялдуулах чиглэлийг Засгийн газарт өгсөн учир буцаан татсан байна. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогду улан үзэл баримтлал, тандан судалгааг боловсруулан батлуулахаар 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 01/3041 дугаар албан бичгээр Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна. Дээр тайлангаас харахад Нийгмийн даатгалын багц хууль Улсын Их Хурлаар хэлэлцэж эхлээгүй буюу 2022 онд батлагдсан байна гэсэн зорилтот түвшиндээ хүрээгүйгээс уг арга хэмжээний хэрэгжилт 30 хувьтай байна.	Нийгмийн даатгалын багц хуулийг УИХ-аар батлуулах
50	2.5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг 6 аймагт байгуулах	50	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкттай 2018 оны 4 сарын 4-ний өдөр байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төслийг хэрэгжүүлж байна. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл "Дархан-Уул, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Ховд аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, эхнээс Хөвсгөл аймгийн барилга ашиглалтад орсон ашиглалтад орж, улсын комисс хүлээн авсан байна. Энэ онд багтаан Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд аймгуудын барилга бүрэн баригдаж ашиглалтад орно. Архангай аймагт баригдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга 42%-ийн гүйцэтгэлтэй байна. Тус барилгын санхүүжилтэд 2022 онд 17,250,000,000.00 төгрөг санхүүжилт төсөвлөгдсөнөөс 15,795,439,082.7 төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.	Үлдсэн 5 аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах
51	2.5.11. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулж, тогтолцооны шинэчлэл хийх ажлыг эхлүүлэх	50	Монгол Улсад Хуримтлалын нэгдсэн сан бий болгоход дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг боловсруулж Дэлхийн банкинд хүргүүлж батлуулжээ. Энэхүү техникийн нөхцөлийн дагуу Сингапураас авах зөвлөх үйлчилгээний 1 ба 2 шатны тодорхой хэсгийг Дэлхийн банкнаас Сингапурын хамтын ажиллагааны байгууллага (SCE)-тай 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан гэрээгээр санхүүжүүлэхээр болсон байна. 2022 оны 8 дугаар сарын 10-16-ны өдрүүдэд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын зөвлөх үйлчилгээний 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Монгол Улсад ажилласан талаар тайланд дурдсан байна. Хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцооны шинэчлэл хийгдэх эхний алхамууд тавигдсан байгаагаас уг арга хэмжээний хэрэгжилт 50 хувьтай байна.	Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх
52	2.5.13. Халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах замаар нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлэх	50	Нийгмийн халамжийн одоогийн хуулийн хүрээнд зорилтот бүлгийн иргэд, өрхүүдэд зөвхөн мөнгөн тусламж үзүүлдэг хэт нэг талыг барьсан бодлогоос татгалзаж, нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдийг чадавхжуулах, тэдний хэрэгцээнд нийцсэн шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан байна. Халамжаас Хөдөлмөрт шилжүүлэх бодлогын арга хэмжээний хүрээнд хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, сургах, зуучлах, бичил зээлд хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.	Халамж авдаг иргэдийн тоог багасгаж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг судалж шийдвэрлэх ажлыг зохион байгуулах.
53	2.5.14. Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийг хийж, зорилтот өрх, иргэнийг тодорхойлох аргачлалыг сайжруулах	30	Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл болон холбогдох төрийн мэдээллийн санг ашиглаж, уялдуулан загварын үнэлгээ, тооцооллыг олон хувилбараар үнэлж, гүйцэтгэлийг сайжруулж буй хувилбаруудыг нэгтгэн, шинэ загварыг боловсруулан загварын үнэн бодит байдлыг шалгаж, эцсийн загварын төслийг боловсруулсан байна. Боловсруулсан хосолмол загварыг турших туршилтын судалгааг УБ хотын 6 дүүрэг, Орхон, Булган, Хэнтий, Дундговь аймгуудын 400 өрхийг хамруулсанаар уг арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй буюу 30 хувьтай байна.	Аргачлалыг боловсронгуй болгож, сайжруулахад анхаарах
54	2.5.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулах	30	Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын зураг, төсвийг 2021 оны 12 дугаар сард боловсруулан баталгаажуулсан ба барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтын дотоодын тендерийг 2022 оны 2 дугаар сард зарлаж, гүйцэтгэлийг шалгаруулж, гэрээ байгуулагдсан. Барилга угсралтын ажил 24% хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2022 онд 3,0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгыг дуусгах

55	2.5.12. Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх	30	"Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр" "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "Ногоон ажлын байрыг дэмжих хөтөлбөр", "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-үүдийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 тогтоолоор батлан 2022-2023 онд хэрэгжүүлжээ. ҮСХ-ны 2020 оны статистик мэдээгээр МУ-ын ядуурлын түвшин 27.8 хувь, 2022 оны 3 дугаар улирлын мэдээгээр МУ-д хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.0 хувьд хүрсэн байгаа нь ядуурлын түвшин 0.6 хувиар буурч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 3.3 хувиар суурь түвшингээс нэмэгдсэн байгаа нь хангалттай биш бөгөөд эрчимжүүлэх шаардлагатай байгаагаас уг арга хэмжээний хэрэгжилт 30 хувьтай байна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг оновчтой хэрэгжүүлж, ядуурлыг бууруулах ажлыг зохион байгуулах.
----	---	----	--	---

2.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.

56	2.6.4. Алтайн өндөр уулыг ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн жагсаалтад, Наурызын баярыг ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх	90	"Алтайн өндөр уулс"-ыг холимог өвийн ангиллаар Дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран бэлтгэж, бүртгүүлэх саналын хамт 2021 оны 01 дүгээр 20-нд конвенцын удирдамжид заасны дагуу Дэлхийн өвийн хороонд, Соёлын яамнаас "Наурызын баяр" өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлэх баримт бичгийг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран бэлтгэж, өвийг бүртгүүлэх саналын хамт 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр өвийн оролцогч 12 улсыг тэргүүлж байгаа Исламын Бүгд Найрамдах Иран Улсын Байнгын төлөөлөгчийн газарт тус тус хүргүүлсэнээр уг арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай байна.	Нэр дэвшүүлэх ажлыг эцэслэн батлуулах.
57	2.6.5. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулах	90	Засгийн газрын 2020 оны 13, 2021 оны 179 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталсан. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, 45.2, 58.5 дугаар зүйлд заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үүргийг Соёлын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний 4.1-т тусган иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн. 21 аймаг, нийслэлийн газар нутагт орших улсын хамгаалалтын зэрэгцэлд орсон нийт 197 дурсгалаас өнөөдрийн байдлаар нийт улсын хамгаалалттай дурсгалын 173-ыг нь буюу 87,8 хувийг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хамгаалуулж байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
58	2.6.7. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II", "Монгол соёл, Монголын баялаг" цогц арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх	70.00	Соёлын бүтээлч үйлдвэрлэл арга хэмжээг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хүрээнд тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний боломжит зах зээлийг тэлэх, экспортод чиглүүлэх зорилгоор "Соёлын бүтээлч сар" аяныг зохион байгуулсан байна. Энэ жил "Монгол цам"-ыг онцолж соёлын өвийн үнэт зүйлс учир түүний утга бэлгэдлийг ухамсарлан ойлгож, баяжуулан хөгжүүлж, хойч үедээ өвлүүлэх зорилгоор сурталчилсан байна. Мөн "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум-2022" болж форумд соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах 12 салбар, 90 гаруй чиглэлийн 400 гаруй төлөөлөл оролцож, хэлэлцүүлгээс гарсан саналыг үндэслэн форумын нэгдсэн зөвлөмж гаргасан байна. Дээрх ажлын хүрээнд уг арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна.	Цогц арга хэмжээг төлөвлөсний дагуу бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
59	2.6.2. Үндэсний номын сангийн шинэ барилгыг бүрэн ашиглалтад оруулах	0	2022.12.09-ний байдлаар Ажлын хэсгийн гишүүд Үндэсний номын сангийн барилгын ажлын гүйцэтгэсэн болон үлдэгдэл ажлын тоо хэмжээг хянаж тулгалт хийхэд 2022.12.13-нд Үүний үр дүнд гүйцэтгэлээр гаргасан тоо хэмжээ барилга дээр хийсэн ажлын тоо хэмжээ зөрсөн, давхацсан асуудал илэрсэн тул чиглэл тус бүрийн хяналтын инженерүүд /цахилгаан, сантехник, барилга/ тухайн үед гаргасан гүйцэтгэл 1-19 хүртэлх холбогдох материалтай нэг бүрчлэн танилцан, тоо хэмжээг нарийвчлан тулгах ажил хийсэн байна. 2022.12.20-ны өдөр "Акви холдинг" ХХК-тай байгуулсан 2014 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 3/206 дугаартай Үндэсний төв номын сангийн барилга угсралт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын ажил гүйцэтгэх гэрээг цуцлахтай холбоотой ажиллагаа болон тус ажиллагаатай холбогдон гарсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, хууль зүйн туслалцаа авах зорилгоор Өмгөөллийн "Жэй Эн Ти партнерс" ХХН-тэй 2022/27 дугаар гэрээ байгуулжээ. Харилцан талуудын маргааны улмаас 2022 онд ажил хийгдээгүйгээс уг арга хэмжээний хэрэгжилт 0 хувьтай байна.	Гэрээ цуцлахтай холбогдон гарах маргааныг хэрэг хянан ажиллагаанд оролцуулан шийдвэрлэх асуудлыг богино хугацаанд шийдвэрлэж Үндэсний номын сангийн барилгыг ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэх.
60	2.6.3. Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх	0	Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээллийн санд RICH 3.0 программ хангамжид нийт Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамруулсан байна. Уг Rich программд бүртгэсэн өвийн бүртгэлийг шууд шинэ системд хөрвүүлэх боломжтойгоор программчлахаар ажлын даалгаварт тусгасан тул одоо ашиглагдаж байгаа программд өвийн бүртгэлийг бүртгэх ажил амжилттай хийгдсэн.	Соёлын өвийн бүртгэл, хяналтын бие даасан системийг хөгжүүлж улсын нийт түүхэн дурсгалт газарын дурсгалыг бүрэн хамруулах ажлыг эрчимжүүлэх.

3. Эдийн засгийн бодлого

3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

61	3.1.2. Зах зээл дэх хэт төвлөрлийг сааруулах, монополь, давамгайл байдлаа урвуугаар ашиглахын эсрэг бодлогын арга хэмжээг авах	70	Засгийн газрын 298 дугаар тогтоолын дагуу 2022 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолоор дагнасан хэрэглээний төмөр замын зах зээлд "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХК-ийг "Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч"-ээр, 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолоор хөнгөн бетоны зах зээлд "Монголын алт МАК" ХХК-ийг "Давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч"-ээр, 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны ипотекийн хоёрдогч зах зээлд Монголын ипотекийн корпораци ОССК" ХХК-ийг "Давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч"-ээр тус тус тогтоож, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллажээ. Монголбанканд "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-д өөрчлөлт оруулах замаар зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.	Монополь, давамгайл байдалтай аж ахуй нэгжид хуулийн дагуу тавих хяналтыг сайжруулах. Төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий бүх аж ахуй эрхлэгчдэд нээлттэйгээр, ил тод байдлаар хүргэж ажиллах.
----	--	----	---	--

62	3.1.3. Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, сайжруулах	70	Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Боршоо, Шивээхүрэн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор боомтын бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна. Гашуунсухайт боомтын ойролцоо байгуулагдсан чингэлэг терминал гаалийн ханалтын бүсэд ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор улсын хилээр орох, гарах чиглэлд тус бүр 1 буюу нийт 2 эгнээ замд ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг сайжруулахаар ажиллаж байна. Рентген: 5-12 км цагийн хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэлд ачсан барааг шалгах эхний ИСБ-А рентгенний Шивээхүрэн боомтод суурилуулсан бөгөөд дараагийн рентгенний Боршоо боомтод суурилуулахаар төлөвлөн 2022 оны 9 дүгээр сард үйлдвэрлэгч компанийн мэргэжилтнүүд байршлыг тодорхойлсон. Түүнчлэн хилийн боомтын шинэчлэл төслийн хүрээнд гаалийн нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад болон дотоод эх үүсвэрээс тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийхэд 120,0 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн. 2022 оны 11-р сарын 22-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаж, барьцаа хөрөнгийн данснаас 5 тэрбум төгрөг чөлөөлсөн.	Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Боршоо, Шивээхүрэн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор боомтын бүтээн байгуулалтын ажлуудыг богино хугацаанд хийж дуусгах мөн улсын хилээр орох, гарах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг сайжруулах.
63	3.1.6. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	70	Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжид 500 сая төгрөг хүртэл, бизнес эрхлэгч иргэнд 50 сая төгрөг хүртэл жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай зээлийг банкуудын чөлөөт эх үүсвэрээр 2.0 их наяд төгрөгийг олгосон. Коронавирусын үед хэрэгжүүлж буй улс, орнуудын төв банкуудын туршлагыг судалж, зээлийг багцлан үнэт цаасжуулан репо нөхцөлөөр санхүүжилт олгох механизмын хүрээнд Монголбанкнаас 2 жил хүртэл хугацаатайгаар банкуудад репо нөхцөлөөр санхүүжилт олгож, банкууд эцсийн зээлдэгчид 10.5 хувийн хүүтэйгээр шинээр зээл олгох, дахин санхүүжүүлж байна. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж тус зээлийн хүүг жилийн 6 хувь болгон бууруулан, Монголбанк болон банкуудын холимог эх үүсвэртэйгээр хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуйн салбарын хаврын тариалалтад 100.0 тэрбум төгрөг, ноос, ноолуур, арьс шир бэлтгэлийн үйл ажиллагаанд 200.0 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай 3.0 хувийн хүүтэй, малчдыг дэмжсэн зээлд 250.0 тэрбум төгрөгийг 3 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй зээлийг олгож байна. 10 их наядын цогц төлөвлөгөөний үр дүнд 2022 оны өдрийн байдлаар 69,221 иргэн, аж ахуйн нэгжид 6,003.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. ТЕГ-аас ирүүлсэн мэдээллийн дагуу зээлд хамрагдсан ирэн, аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар өссөн эерэг өөрчлөлт гарсан байна. Зээлийн батлан даалтын сангаас 208 зээлдэгчид 28.3 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргав. Төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндээ хамгаалах зорилтын хүрээнд цар тахлын эсрэг вакцинжуулалт 2021 оны байдлаар 2,283,523 иргэнийг 1-р тунд, 2,184,678 иргэнийг 2-р тунд хамруулсан.	ХАА-г дэмжих зээл олголтыг 100.0 хувьд хүргэх, Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж тус зээлийн хүүг жилийн 6 хувь болгон бууруулах боломжийг судлан шийдвэрлэх. 10 их наядын цогц төлөвлөгөөний дагуу иргэн, аж ахуйн нэгжид олгох зээлийг нэмэгдүүлэх.
64	3.1.7. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг шийдвэрлэх цогц тогтолцоог бүрдүүлэх	70	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудал хариуцсан зөвлөлийн эрх үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон төрийн байгууллагуудаас хөрөнгө оруулагчдын гомдол, маргааныг шуурхай шийдвэрлэх талаар тусгах арга хэмжээний зохицуулалтыг шинээр тусгасан. - "Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргуулсан. Гадаад улсаас Монгол Улсад суугаа 13 Элчин сайдын яамнаас ирүүлсэн гомдол, тулгамдаж буй асуудлын талаар судалгаа; -20 хуулийн фирмээс гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч иргэдэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэхэд холбоотой тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл болон эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой судалгаа; -SIRM системд ирүүлсэн 20 гомдолд анализ хийж, улмаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцүүлж батлуулах, гадаадын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл үүсгэж хамтран ажиллахад хүндрэл үүсэхгүй байх талаар судалж шийдвэрлэх.
65	3.1.9. "Замын-Үүд" чөлөөт бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, экспортод чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах	50	Замын-Үүд" чөлөөт бүсэд хөрөнгө оруулах аж ахуйн нэгжүүдийг найдвартай эрчим хүчээр хангах ажлын хүрээнд "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хийгдсэн цахилгаан дамжуулах 16 ш 10/0.4 кВТ-ын дэд өртөөний 0.4 кВТ талын тоноглол угсрах, шалны засварын ажлыг Эрчим хүчний яамны захиалгаар "Улаанбаатар электро мантаж" ХХК гүйцэтгэсэн. Тус ажлын гүйцэтгэл бүрэн дуусаж Эрчим хүчний үндэсний төв болон БЗӨБЦТС ТӨК-аас 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр техникийн комисс ажилласан. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 280 дугаар тогтоолоор Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан зохицуулах зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг, Гадаад харилцааны сайдын 2022 оны А/69 дүгээр тушаалаар Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг тус тус баталж хятадын талд дипломат шугамаар мэдэгдэн анхдугаар хуралдааныг товлон хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. "Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах бэлтгэлийг ханган ажиллаж байна. "Замын-Үүд" чөлөөт бүсэд 7 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхлүүлж, 11 аж ахуй нэгж барилгын ажлын бүтээн байгуулалтыг гүйцэтгэсэн байна.	"Замын-Үүд" чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах. Аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл үүсэхгүй байх бүх талын арга хэмжээг авч ажиллах.
66	3.1.4. "Алтанбулаг" чөлөөт бүсийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох	0	"Алтанбулаг" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас төсөлд шаардагдах төсвийг бусад шаардлагатай дэд бүтцийн төслүүдэд шаардагдах хөрөнгө оруулалтын саналын хамт Монгол Улсын 2023 оны төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсөвт тусгагдаагүй. Гаалийн ерөнхий газарт гаалийн бүртгэлийн системд цогц шийдлийг олж нэвтрүүлэх, бүсийн зорчигч, тээврийн нэвтрэлтийг хурдасгахад холбогдох арга хэмжээ авах тухай албан бичгийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/1697 тоот албан бичгээр хүргүүлснээ.	"Алтанбулаг" чөлөөт бүсийн төсөлд шаардагдах төсвийг улсын төсөвт тусгах, чөлөөт бүсээр нэвтрэх гаалийн бүртгэлийн системийг болон зорчигч тээврийн нэвтрэлтийг хурдасгах ажлыг зохион байгуулж шийдвэрлэх.

67	3.1.5. Зээлийн хүүг бууруулах стратегийг эрчимжүүлж, зээлийн хүүг үргэлжлүүлэн бууруулах	30	Зээлийн хүүг бууруулах стратегийг УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаартай тогтоолоор батлан, Монгол улсын Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран хэрэгжүүлж, стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнан ажиллаж байна. Тус стратегийн баримт бичиг нь 4 заалт, 4 дэд заалтын хүрээнд тодорхойлсон 19 арга хэмжээ, 47 дэд арга хэмжээнээс бүрдсэн бөгөөд дараах үндсэн 4 чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд: зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх; зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах; банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах; хөрөнгийн захыг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах зэрэг байна. Монголбанкнаас КОВИД-19 цар тахлын үед нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжих ажлын хүрээнд бодлогын хүүг 2020 онд 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэсэн бөгөөд 2021 оны туршид хэвээр хадгалсан. Үүний үр дүнд шинээр олгосон зээлийн дундаж хүү 2019 оны 2 сард 16.9 хувь байсан бол 2020 оны төгсгөлд 14.8 хувьд хүрч, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 15.3 хувьтай байна. Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам гаргадаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр сард гаргахаар хүлээгдэж байна.	Зээлийн хүүг бууруулах стратегийг эрчимжүүлж, зээлийн хүүг бууруулах арга хэмжээг авах ажлыг зохойн байгуулах.
68	3.1.8. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах	30	1. Хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд: - Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах асуудал хариуцсан зөвлөлийн эрх үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон төрийн байгууллагуудаас хөрөнгө оруулагчдын гомдол, маргааныг шуурхай шийдвэрлэх талаар тусгах арга хэмжээний зохицуулалтыг шинээр тусгасан. - Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 сарын 23-ны өдрийн хуралдаанд гадаадын хөрөнгө оруулагчдаас гаргасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор "Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол гаргуулсан. 2. Хөрөнгө оруулагчдад учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх хүрээнд: - Гадаад улсаас Монгол Улсад суугаа 13 Элчин сайдын яамнаас ирүүлсэн гомдол, тулгамдаж буй асуудлын талаар судалгаа; -20 хуулийн фирмээс гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч иргэдэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэхэд холбоотой тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл болон эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой судалгаа; -SIRM системд ирүүлсэн 20 гомдолд анализ хийж, улмаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. 3. Бусад: - МУ-ын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар захирамжаар байгуулсан Швейцарын Холбооны Улсад бүртгэлтэй "Даблюэ Эм Майнинг АГ" компани, түүнийг төлөөлж "Мэйер Браун Интернэшнл" хуулийн фирмтэй маргааныг хэлэлцээ хийж замаар шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсэг, 2021 оны 87 дугаар захирамжаар байгуулсан Америкийн Нэгдсэн Улсын "Даблюэ Эм Майнинг" компанийн гаргасан нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газарт холбогдох арбитрын маргааны хууль зүйн үндэслэлийг судалж, холбогдох тайлбар, нотлох баримтыг гарган нэхэмжлэлийн шаардлагыг няцааж, Засгийн газрын байр суурь, чиглэлийг хамгаалах үүрэг бүхий Ажлын хэсэгт Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр болон холбогдох танилцуулга, саналыг хүргүүлж ажилласан байна.	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцүүлж батлуулах, гадаадын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл үүсгэж хамтран ажиллахад хүндрэл үүсэхгүй байх талаар судалж шийдвэрлэх.
3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.				
69	3.2.6. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх	90	1. 2022 онд хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент-/ийн ӨТТЭ-1-2021, ӨТТЭ-2-2022 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан. 2. ӨТТЭ-1-2021 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХУСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эдийн судалгаа /ӨТТЭ-2-2022/-ны геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХУ-ийн Дэд сайд баталсан. 4. ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэлтэй зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. 5. Дээрх 2 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг УГА-тай хамтран 2022.11.15-17-ны өдрүүдэд хүлээн авсан.	Судалгааны ажлыг эрчимжүүлэх.
70	3.2.20. Зүүн Цагаан дэгийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах	90	Зүүн цагаан дэгийн далд уурхайн эхний ээлжийг 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. Зүүн Цагаан дэгийн хайлуур жоншны далд уурхайн 2 налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 1199.5 у.м нэвтэрч, /9894,7 м3 уулын цул нураасан уулын ажил хийж 78.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Уурхайн доод түвшин 1150 м. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмпиин барилга байгууламжийн ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэгийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 50 хувьд хүрсэн.	Уурхайн цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмпиин барилга байгууламжийн ажлыг дуусгаж жоншны далд уурхайг ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэх.
71	3.2.3. Геохимийн 1:1000000-ны масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулах	70	1. 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км2 талбайг буюу 32.1%-ийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нутаг дэвсгэрийн үлдсэн хэсгийг уг судалгааны ажилд бүрэн хамруулахаар хэрэгжүүлж эхэлсэн. 2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км2 буюу 67.9%-д хээрийн судалгаагаар хамруулан холбогдох дээжлэлтийг авч дууссан. 2. 2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнгээр боловсруулах тайлангын суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн. 3. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХУСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 4. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын анхдагч баримт, материалыг УГА-тай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авсан.	Төслийн суурин боловсруулалтын ажлыг богино хугацаанд дуусгах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулж геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг эхлүүлэх.

72	3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	70	1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХУ-ийн Дэд сайдаар батлуулан, геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.07.08-нд гүйцэтгэгчтэй байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 3. Төслийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авсан.	Геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний судалгааны ажлыг дуусган тус судалгаанд үндэслэн геологийн мэдээллээр бүрбүүлж, баяжуулах ажлыг эрчимжүүлэх.
73	3.2.5. Бүс нутаг болон хотуудын геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх	70	1. 2022 онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан, Ховд хотын геозкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геозкологи-2019, ДА геозкологи-2020, ХО геозкологи-2021 болон Хангай, Хөвсгөл, Хэнтийн районы халуун рашааны геотермийн Гүний хагарал-1, Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2022 нэртэй төслийн төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталж, ажлыг эхлүүлсэн. 2. Төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХУСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3.2022 онд Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 4. ХО геозкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн хээрийн судалгааны ажилд 8-р сард шуурхай хяналтыг хийсэн. 5. ДА геозкологи-2020, ХО геозкологи-2021 төслүүдийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.28-нд, Гео орчин-2022, Гүний хагарал-1 төслийн материалыг 2022 оны 12 дугаар сарын 01-нд хүлээн авсан.	Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг ЭБМЗ-ийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах ажлыг шийдвэрлэх.
74	3.2.8. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх	70	1. 2022 онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагенийн судалгааны Мезо-Кайнозой-2021 болон шинээр хэрэгжүүлэх Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийг төсөв, төлөвлөгөөг УУХУСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХУ-ийн дэд сайд баталсан. 2 Мезо-Кайнозой-2021 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХУСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгч хуулийн этгээдтэй геологийн судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10, 2022.07.08-нд байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 4. БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлыг 2022.11.16-20-ны өдрүүдэд хүлээн авч, баталгаажуулсан байна.	Судалгааны ажлыг гэрээний дагуу эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах.
75	3.2.9. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлвийн үнэлгээ өгөх	70	Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх Эрэл үнэлгээ-4-2022 төслийн геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХУ-ийн Дэд сайд баталсан. 3. Эрэл үнэлгээ-4-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 4. Төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг 8-9 дүгээр сард хийсэн. 5. Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.15-21-ны өдрүүдэд хүлээн авсан байна.	Эрэл үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах.
76	3.2.11. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх	70	Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.12.16-ны өдрийн байдлаар 77.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-81%, Хоолны газар-90%, Лаборатори-90%, Эмнэлгийн барилга-84%, Агуулах-63,7%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-57%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. ЕРС-2, ЕРС-3 багц ажлын тендер хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын "Megha Engineering & Infrastructure Limited" (Мега инженеринг инфраструкчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, "Megha Engineering & Infrastructure Limited" компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс техноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг боловсруулж байна.	Барилга угсралтын ажлыг 100 хувьд хүргэх, тендерт шалгарсан компанитай хамтарч ажиллах ажлыг эрчимжүүлэх, гэрээний дагуу үүргээ гүйцэтгүүлэхэд анхаарах.

77	3.2.10. Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах	50	Сүхбаатар аймгийн ИТХ-ын тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэн батлуулах ажил хүлээгдэж байна. Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт, дагалдах баримт бичгийн бүрдэлийг хангаж тухайн сумдын Засаг дарга болон газрын албаар баталгаажуулах. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхлүүлээд барилга угсралтын ажил -35%, түр замын ажил -15%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -60%, геотехникийн судалгааны ажил -80%, дээжлэлт шинжилгээ -80%-тай байна. Тосон-Уул 19, Тамсар XXI талбайн нэгдсэн байгууламжаас 17,5 л ба 16,7л дээж авч тосны дээжийг БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторт илгээсэн, хариу хүлээгдэж байна. Канад Улсын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлыг 10-р сарын 15-ны өдрөөс эхлүүлээд ажил -25% байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННУ хийх ажил 90 хувь хийгдсэн.	Газрыг гэрчилгээжүүлэх ажлыг тухайн сумдын Засаг дарга болон газрын албаар баталгаажуулах. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг богино хугацаанд барьж дуусгах.
78	3.2.12. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах	50	Засгийн газрын 2017 оны 92 дугаар, ТӨБЗГ-ын 2017 оны 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит компанийг байгуулсан. ЗГХЭГ-ын дарга болон УУХУСайд нарын 2021 оны 16-А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэг ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит "Эрчис Ойл" ХХК, "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨГ, "Эрдэнэс метан" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 47 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан УУХУСайд 2021 оны 03 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн. Газрын тосны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусган боловсруулж байна.	Газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг Засгийн газраар батлуулах асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах. Газрын тосны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусган УИХ-аар хэлэлцэн батлахад анхаарах.
79	3.2.17. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг үргэлжлүүлэх	50	Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 20%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 46.1 хувь байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 69.7 хувьд хүрсэн байна.	Ачилтын нэгдсэн төвийн болон Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгах, нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэлийг эрчимжүүлэхэд анхаарах.
80	3.2.18. Үнэт металлын сорьцын хяналтын газрын сорьц тогтоох лаборатори байгуулж үнэт металлыг сорьцох, эрдэнийн чулууг тодорхойлох үйл ажиллагааг өргөжүүлэх. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	50	2022 онд салбар лабораторийг Зүүн бүсэд буюу Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэд байгуулахаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн. Хэнтий аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн байранд тус лабораторийг байрлуулахаар 89,23 метр квадрат 3 өрөөг бэлтгээд байна. - Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуульд Үнэт металлын сорьц тогтоох үйл ажиллагааг зөвхөн сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтоох нь зохимжгүй гэж үзэж сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд мөн хийж гүйцэтгэх болохоор заасан. Иймд эрх бүхий байгууллагаас шийдвэр гарах ажил хүлээгдэж байна. (Эрдэнэсийн сангийн тухай хууль: 15.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд, эсхүл сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх үүрэгтэй.)	Зүүн бүсэд байгуулах салбар байгуулах ажлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэн байгуулах ажлыг эрчимжүүлэх.
81	3.2.19. Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх	50	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох бусад албан бичиг, материалуудыг УУХУСайдын 2022.12.15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад хүргүүлсэн.	Хуулийн төслийг эцэслэн УИХ-аар батлуулах ажлыг эрчимжүүлэх.
82	3.2.7. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах	30	Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 30-нд байгуулж судалгааны ажлыг эхлүүлсэн байна.	Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байгууллагыг гэрээний дагуу ажлаа гүйцэтгэхэд анхаарч ажиллах.
83	3.2.13. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх	30	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7 хувьтай хэвээр байна.	Туршилт, судалгааг эрчимжүүлж хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах.

84	3.2.14. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих	30	Батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна. Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц барьж байгуулах ажлын хүрээнд: - Автозам барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 3 дахь удаагийн тендер хүчингүй болсон, 4 дэх тендер зарлахаар ажиллаж байна. - Төмөр зам барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2 дахь удаагийн тендерийг 2022.11.07-нд зарласан бөгөөд 2022.12.12-ны өдөр нээсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна. - Ус хангамж, ариутгах татуургын системийг барьж байгуулах ажлын тендер хүчингүй болсон. Дахин тендер зарлахаар ажиллаж байна. - Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэхээр болж, ажлын төсөвт өртгийг батлуулах ажил хийгдэж байна. "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Засгийн газрын 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн Засаг дарга нар 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр №000000019 дугаартай газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр авсан байна.	Дэд бүтэц барьж байгуулах хүрээнд ажил тус бүрээр зарласан тендерийн сонгон шалгаруулалтад анхаарч ажиллах, шалгарсан гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэхэд хуулийн дагуу хяналт тавьж ажиллах.
85	3.2.15. "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх	30	Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын "Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж" боловсруулсны дагуу "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Худалдан авах ажиллагааны газарт 2022.09.22-ны өдөр хүргүүлсэн ба Үнэлгээний хороо байгуулагдаж тендер зарлахаар ажиллаж байна.Валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан тус ажлын төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна. Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinjin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулахаар төлөвлөсөн. Туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 98%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 96%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба үлдсэн тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгдэх шатанд байна. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн.	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлын сонгон шалгаруулалтын тендерийг зарлах ажлыг эрчимжүүлж барилгын ажлыг эхлүүлэхэд анхаарах.
86	3.2.16. "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих	30	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-ийн боловсруулсан "Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааны 2022.06.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Гэвч "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2022.11.04-ний өдрийн хуралдаанаар тус ТЭЗҮ-ийг хэлэлцэж, Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулах, үүнд шаардлагатай хугацааг харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах, ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй 2022.12.14-ний өдөр цахим хурлыг зохион байгуулж ТЭЗҮ-ийг шинэчлэн засварлахаар тохиролцсон байна. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 30 хувьтай байна.	Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр барих ажлын ТЭЗҮ-г холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэн батлуулж, барилгын ажлыг эхлүүлэхэд анхаарах.
87	3.2.21. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах	0	Дорноговь аймагт "МДМУ" ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил цар тахал, хилийн хорио, үлдэгдэл хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас 2022 оны 12 дугаар сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн нэмэлт хөрөнгө оруулалтын хувилбаруудыг судалж байна.	Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд анхаарах.
3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.				
88	3.3.3. Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулах	90	Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлэх үрийн чанар хангамжийг сайжруулах чиглэлээр "Шинэ сортын улаанбуудайн супер элит үр гаргах" зөвлөх үйлчилгээг зарлан улсын төсвийн 260.0 сая төгрөгийн санхүүжилтээр Дархан Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн хүрээлэн зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхээр шалгарч 05 сарын 04-ний өдрийн 220505/05-237 дугаар гэрээ байгуулсан ба 11 дүгээр сарын 26 ны өдөр ажлын хэсэг гэрээт ажлыг хүлээн авсан байна. Үржүүлгийн анхдагч 9 тн буудайн үр, бөөний сонголтын аргаар гаргасан 56 тн үржүүлгийн үрийг гарган гэрээт ажлыг Дархан-уул аймаг дахь ХААДС-нд хүлээн авлаа. Үүний үр дүнд 2023 оны үр үржүүлэх тариалалтад тариалснаар 2024 оны тариалалтад 350 тн супер элит үрийн нөөц бүрдүүлэх юм. 2022 оны ургацаас аж ахуйн нэгжүүд өөрийн тариалалтын үрийн хэрэгцээнд 48.0 мянган тн . Онцгой байдлын ерөнхий газар, ХААДС-нд нийт улаанбуудайн үр 5.0 тн үр нөөц бүрдүүлсэн. Төмсний үр үржүүлэгч Шар чулуут ХХК, Хонгор буудай ХХК, Ньюкроп ХХК, Шандас өгөөж ХХК аж ахуйн нэгжид 37.5 тн элит үрийг Засгийн газрын тогтоолоор хөнгөлөлттэй олгосон бөгөөд 15 га -д тариалж 270 тн үрийн ургац хураан авч 2023 оны тариалалтад нөөцөлсөн. Аж ахуйн нэгж, өрхүүд 45.0 мянган тн үрийн нөөцтэй байна. УГТХ болон үр үржүүлэгч Элит үр ХХК вирусгүй бичил булцуу 180.0 мянган ширхэг үр хураан авч нөөц бүрдүүлэв. Хүнсний ногооны 35.0 тн үр нөөцөлсөн.	Үрийн нөөц бүрдүүлэх болон үрийн чанарт анхаарч ажиллах.

89	3.3.9. Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, Төвийн бүсийн үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	90	Малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх систем www.nlis-2.mofa.gov.mn , Хурдан морины бүртгэлийн систем www.horse.mofa.gov.mn , Сүргийн эргэлтийн тооцоолох систем www.herd.mofa.gov.mn , Малын удмын сангийн бүртгэлийн модул, Тэжээлийн тогтвортой менежмент, шийдвэр гаргалтыг дэмжих систем www.fodder.mofa.gov.mn зэрэг мэдээллийн системүүдийг нэгтгэн Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг www.livestock.mofa.gov.mn домайн хаягаар үүсгэж Үндэсний дата төвийн төрийн үйлчилгээний систем төрийн клауд дэд бүтэц рүү шилжүүлэх тасралтгүй ажиллагааг хангаж, мэдээллийн технологи, систем ашиглах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байна. Малын генетик нөөцийн хэлтэс ҮСХ-ны А данс дээр үндэслэн нэг бүрчлэн эсвэл бөөн дүнгээр малчин өрх, малын төрөл, удам гарваль нас, хүйс, тоог бүртгэсэн байна. Хавар, намрын технологит хугацаанд 2 аймгийн 21 сумын 158.2 мянган үржлийн мал, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 16 аймгийн 71 сумын 271.6 мянган үржлийн малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх ажлыг хийж, хавар, намрын технологит ажлыг Мал үржүүлгийн технологийн ажил үйлчилгээний 42 нэгж гэрээгээр гүйцэтгэж, нийт 316 хүн, 87 техник хэрэгсэл ажиллаж, орон нутагт 250 гаруй түр ажлын байр бий болгосон байна. Технологийн хугацаанд 2022 онд 232.0 мянган малыг (төвийн бүсийн 7 аймгийн 49.7 мянган үхэр) ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн ба төрлөөр нь авч үзвэл 309 тэмээ, 6.7 мянган адуу, 67.3 мянган үхэр, 93.3 мянган хонь, 64.2 мянган ямаа байна. Өссөн дүнгээр 4.6 сая малын мэдээлэл бүртгэгдсэн.	Бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, мэдээллийн санг бүрэн бүрдүүлэхэд анхаарах.
90	3.3.19. Хүнсний ногоог дотооддоо тариалахад дэмжлэг үзүүлэх	90	Хүнсний ногоог дотооддоо тариалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 118 дугаар тогтоолоор ил талбайн болон хүлэмжийн хүнсний ногооны үрийг 80 хувь хөнгөлөх шийдвэр гарсаны дагуу хүнсний ногооны үр нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж үрийг нийлүүлэн Хүнсний ногооны үрийн хуваарийг ХХААХУ-н сайдын А-120, А145 дугаар тушаал батлуулан улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгөөр 12 нэр төрлийн 81 тонн үрийг ногоочидод аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудаар дамжуулан олгосон байна. 2022 оны Ургац хураалтын урьдчилсан дүнгээр 19.7 мянган га-гаас 215.5 мянган тонн төмс, 11.8 мянган га-гаас 146.8 мянган тонн хүнсний ногоо авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад төмс, хүнсний ногооны ургац тус бүр 18-25 хувиар тус тус нэмэгдсэн байна.	Хүнсний ногооны үрийн олголтыг нэмэгдүүлэх.
91	3.3.4. Тариалангийн талбайн хог ургамал, хортон шавж, ургамлын өвчин, мэрэгч гэх мэт хөнөөлт организмын тархалтын судалгааг хийх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	70	Ургамал хамгааллын тухай хуулийн дагуу жил бүр тариалангийн талбайн хөнөөлт организмын тандан судалгаа, хөнөөлийг тодорхойлох, тэмцэх арга хэмжээ боловсруулах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 2023 онд "Төвийн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Орхон, говийн бүсийн Говь-Сүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын тариалангийн талбайн ургамлын өвчин, хог ургамал, хортон шавж, мэрэгчийн /хөнөөлт организм/ тархалт, олшролт, хор хөнөөлийн судалгаа" зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр УХЭШХ-тэй гэрээ байгуулсан байна. Энэхүү судалгаанд төлөөлүүлэн дээрх 8 аймгийн 60 сумын тариалангийн талбайн 34392 га талбай хамрагдсан. Хөнөөлт организмын тархалт, тэмцэх арга хэмжээ цаашид анхаарах асуудлын талаар ажлын хэсэгт танилцуулж судалгааны үеэр шинээр илэрсэн хорио цээртэй болон хязгаарлагдмал тархалттай хөнөөлт организмын талаар арга хэмжээ авах, говийн бүсэд төмс, хүнсний ногоо, хүлэмжийн тариалалт ихэссэнтэй холбогдуулан тус аймгуудын газар тариалангийн мэргэжилтнүүд болон тариаланчдыг ургамал хамгааллын арга хэмжээ болон хөрсний үржил шимийг сайжруулах чиглэлээр танхимийн болон талбайн сургалтыг зохион байгуулах, хорио цээртэй хөнөөлт организмыг цаашид тархахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээ авах талаар онцлон тэмдэглэсэн байна. Тус хүрээлэнгээс санал зөвлөмжийн дагуу мэдээллийг нэгтгэн ирүүлсэн ба хөнөөлт организмыг таних каталоги, тэдгээрийн тархалтын зураг, тэмцэх арга хэмжээг боловсруулан ирүүлсэн тул ажлын хэсгээс гэрээт ажлыг бүрэн хийсэн гэж үзсэн. Мөн Ажлын даалгаварт заасны дагуу тус оны 6 сард таримал ургамлыг хөнөөлт организмоос хамгаалах зорилгоор урьдчилсан зөвлөмжийг ирүүлсний дагуу аймгуудын ХХААГ-т хүргүүлэн ажилласан байна.	Хийгдсэн судалгааны мөрөөр тариалангийн талбайн хог ургамал, хортон шавж, ургамлын өвчин, мэрэгч гэх мэт хөнөөлт организмыг устгах, цаашид нэмэгдэхгүй байх талаар ажлыг зохион байгуулахад анхаарах.
92	3.3.5. Махны нөөц бүрдүүлэх	70	Засгийн газрын 174 дүгээр тогтоолд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжид шаардлагатай 130.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1 жилийн хугацаатай, жилийн 3 хувь хүүтэй, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд улсын төсвөөс олгох татаасыг тухайн зээлийн нийт хүүгийн 10.5 хувьтай тэнцүү хэмжээгээр санхүүжүүлэхийг шийдвэрлэсэн. Түүнчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк хамтран нөөцийн мах бэлтгэлийн эх үүсвэрийг банкны саналд үндэслэн урт хугацаат репо арилжаагаар Монголбанкнаас 3 арилжааны банк (Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк)-д 63.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, өнөөдрийн байдлаар 10 аж ахуйн нэгж, 50.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгох тухай шийдвэрийг арилжааны банкнаас гаргаад байна. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэхэд арилжааны банкны шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй холбогдох гэрээг байгуулах, тохиролцох, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжийн тоо болон тэдгээр олгох зээлийг нэмэгдүүлэхэд анхаарч нөөцийн махны хэмжээг иргэдэд хүртээмжтэй байдлаар бэлтгэхэд анхаарч ажиллах.
93	3.3.8. Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулах	70	"Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх" тендерийг 2 удаа зарласан боловч тослог ургамлын үр нийлүүлэх шаардлага хангасан оролцогч шалгараагүй болно. Иймд таримлын тариалалтын технологийн хугацаанд үр нийлүүлэх боломжгүй болсон тул ажлын хэсгээс тус тендерийг хүчингүй болгож, зориулалтыг өөрчлөх санал зөвлөмжийг захиалагчид хүргүүлэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан суулгац үржүүлгийн төв байгуулах тендерийг зарлан гэрээ байгуулан гэрээт ажлыг хүлээн авсан. Аж ахуйн нэгжүүд өөрсдийн санхүүгийн эх үүсвэрээр 2022 оны хаврын тариалалтад шаардлагатай үрийн нөөцийг бүрдүүлж, 124.3 мянган га талбайд тосны ургамал тариалж, 45.7 мянган тонн тосны ургамал хураан авсан байна.	Үрийн нөөц бүрдүүлэх болон үрийн чанарт анхаарч ажиллах.

94	3.3.10. Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхыг сайжруулах	70	Итали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 440.5 сая төгрөгийн үнэ бүхий 8 тоног төхөөрөмжийг Монголын Ноос Ноолуурын Холбооны дэргэд байгуулсан "Итали-Монголын Текстил (нэхмэл)-ийн технологийн төв"-д суурилуулан тохируулж, төвийн үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр албан ёсоор нээсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвд биохимийн шинжилгээ, туршилтын лаборатори байгуулах асуудлаар 1 сая ам.долларын санхүүжилтийг Экспортыг дэмжих төслийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан байна. НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО)-тай хамтран 2022 оны батлагдсан төсөвт өртөг багтаан эхний ээлжинд худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалтыг гарган Дэлхийн банкинд хүргүүлсэн. -Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр биомеханикийн лаборатори, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх болон мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор туршилтын цехийн тоног төхөөрөмжийн санал батлагдан 2023 онд худалдан авалт зарлагдахаар төлөвлөгөөнд оруулж баталсан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвд ажиллан, арьс ширэнд хүнд метал тодорхойлох шинжилгээ, туршилтын лаборатори байрлах, шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулах өрөө талбайг чөлөөлөх бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	Шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмжийг худалдан авах болон шинэ технологи, инноваци нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх.
95	3.3.11. Цахим хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг байгуулж, Хөдөө аж ахуйн биржийн шинэчлэлийг хийж, хоршооны бүтцэд тулгуурлан бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгон загвар хоршоодыг байгуулах	70	Хөдөө аж ахуйн бирж нь блокчейн технологид суурилсан арилжаа, клиринг, төлбөр тооцооны шинэ платформыг нэвтрүүлсэн бөгөөд 21 аймагт түүхий эдийн 96 агуулахад итгэмжлэл олгож, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч 22 хоршоог байнгын бус гишүүнээр элсүүлсэн. Хөдөө аж ахуйн бирж нь 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 996 хэлцлээр 1 их наяд 70 тэрбум төгрөгийн 157 удаагийн арилжаа зохион байгуулсан. Арилжааны дийлэнх хувь нь түүхий эдийн боловсруулах үйлдвэрээс экспортлогч компанийн хооронд хийгдэж байгаа ба бирж орон нутгийн хоршооноос дотоодын үйлдвэрийн хооронд арилжаа зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд 6 аймгийн 32 хоршоог биржийн байнгын бус гишүүнээр бүртгэн гэрээ байгуулан ажиллаж байгаа ба Хэнтий, Төв аймгийн сумдын 3 хоршооноос нийт 230 богц ноолуурын арилжааг 3 удаа амжилттай зохион байгуулсан. Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Сүмбэр багт "Баялаг гүрэм" загвар хоршоог 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан. Тус хоршоонд Японы ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага Жайка-ийн хэрэгжүүлж буй төслийн санхүүжилтээр 38.0 сая төгрөгийн хонины ноос хяргах тоног төхөөрөмж хүлээлгэн өгч цаашид ноосыг чанар стандартын дагуу бэлтгүүлэх ажлыг эхлүүлсэн байна.	Загвар хоршоодын тоог нэмэгдүүлэх, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлэх.
96	3.3.12. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх	70	ЗГ-ын 113 дугаар тогтоолын дагуу төсөл сонгон шалгаруулах 3 дугаар шат буюу газар дээр нь төсөлтэй танилцаж, төсөл хүлээн авах хугацаанд нийт 867 төслийн 105.4 тэрбум төгрөгийн хүсэлтийг ирүүлснээс цахим системд 571 аж ахуйн нэгж 82.4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтээ баталгаажуулснаас ХХААХҮСайдын тушаалын дагуу 22.5 тэрбум төгрөгийг шийдвэрлэхээр болсон байна. Мөн Өмнөговь аймаг нь өөрийн орон нутгийн эх үүсвэрээс аймгийнхаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор 5 тэрбум төгрөгийг батлан 84 төслийн сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж аймгийн хөнгөлөлттэй зээлийн төслийн сонгон шалгаруулалтын дэд хорооны шийдвэрээр 32 төсөлд 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн байна. ЗГ-ын 2021 оны 42, 59, 131, 216 дугаар тогтоол, 2022 оны 117, 144, 175 дугаар тогтоол болон "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд хөдөө аж ахуйг дэмжих /ноос, ноолуур, арьс, шир бэлтгэл үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл, нөөцийн мах бэлтгэл, гурил тэжээл, ургамлын тосны үйлдвэрлэл, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл/ чиглэлээр арилжааны банкны эх үүсвэрээр 2021 онд олгосон 196.4 тэрбум төгрөгийн зээл, 2022 онд олгосон 261.8 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн ЗГ-ын хариуцан төлөх 10.65 хувийн хүүгийн дэмжлэгт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 32.6 тэрбум төгрөгийг Монгол Банкаар дамжуулан санхүүжүүлээ. ЖДҮХСангийн Зээлийн батлан даалтын сангаас 32 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 11,789 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 22.32 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Батлан даалтын үр дүнд 1250 ажлын байр шинээр бий болсон.	Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судлаж, шийдвэрлэх.
97	3.3.13. Жижиг, дунд үйлдвэрийн бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулах, томруулах бодлогыг боловсронгуй болгох	70	Монголын Бизнес Инкубаторуудын Үндэсний нэгдсэн Холбооноос 2022 онд "Монгол улсын төслийн стандар ISO MNC 21500", "Залуучуудын гарааны бизнесийг дэмжих", "Орон нутагт хоршоо, нөхөрлөл байгуулах иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх", "Хөдөлмөрт бэлтгэх сургалт" зэрэг чиглэлээр 4 сургалт зохион байгуулж нийт 105 хүнийг чадавхжуулж, сургагч багшаар бэлтгээд байна. ЖДҮҮЭ-ийг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийн есөлтийг хангах, ажлын байрыг бий болгох замаар экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Төрийн банктай хамтран ажиллаж Төрийн банкны инкубатор төвүүдэд бүртгүүлэх хүсэлтэй ААН, хувь хүмүүсийн мэдээллийг хүргүүлсэн байна. Төрийн банк нь 21 аймаг, 7 дүүрэгт инкубатор төвийг байгуулж, 1,200 гаруй бизнес эрхлэгчийг сургалт, мэдээллээр хангаж, 4,226 ажлын байрыг хадгалж ажиллажээ.	Банкуудтай хамтарсан инкубатор төвийн тоог нэмэгдүүлж, тэдгээр хамрагдаж сургалт мэдээллээр хангагдах, ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах.
98	3.3.16. "Шинэ Хөвд" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	50	Түлхүүр гардуулах нөхцөлтэй "Шинэ хөвд үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв боловсруулах, барих" ХХААХҮЯ/202202143 дугаар бүхий 6 багц нээлттэй тендер шалгаруулалтыг Багц:1 "Авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, үерийн усны суваглал, хашаа, зогсоолын зураг төсөв боловсруулах, барих" ажлыг Таванбогд оффрөүд ХХК, Багц:2. "Саарал ус зайлуулах, усан хангамж, ариутгах татуургын цуглуулах гол шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг "Вокон констракшн" ХХК, Багц:3. "Цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг "Эм ай эс эс" ХХК, Багц:4 "Мэдээлэл холбооны сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг "Монкабель системс" ХХК, Багц:5 "Арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах, барих" ажлыг Жаргалантлуу ХХК, Багц:6 "Уурын дулааны дэд станц, шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, барих" ажлыг Жаргалантлуу ХХК-иуд шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. УТП-ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэхэд шаардлагатай зураг төсвийг боловсруулан магадлал хийлгэн батлуулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон.	Хийгдсэн зураг төсвийн дагуу бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ажлыг эрчимжүүлэх.

99	3.3.17. Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх	70	Говь ХК 8,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Итали улсын иж бүрэн 2 самнах машин шинээр суурилуулж, байнгын 10 ажлын байрыг бий болгон эзрэх хүчин чадлыг 350 тонноор нэмэгдүүлснээр улсын хэмжээнд нийт эзрэх хүчин чадал 2970 тн-д хүрсэн. "Баялаг Өлзий" ХХК нь 300,0 мянган ам.долларын үнэ бүхий хялгас ялгаж 40 тоног төхөөрөмж суурилуулан хүчин чадлаа 40 тн-оор нэмэгдүүлж, 20 ажлын байр бий болгосон. Итали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар "Итали-Монголын Текстиль (нэхмэл)-ийн технологийн төв"-ийг байгуулж, төвийн үйл ажиллагааг нээсэн байна. Хөдөө аж ахуйн зээл олгох тухай Засгийн Газрын 2021 оны 42, 2022 оны 117 дугаар тогтоолын дагуу ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлд 150.0 тэрбум төгрөг, ноос бэлтгэл, үйлдвэрлэлд 25.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгохоор батлуулсан. 2022 оны 12 дугаар сарын байдлаар ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 31 аж ахуйн нэгжид 106,96 тэрбум, ноос бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар 8 аж ахуйн нэгжид 8,01 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгоод байна.	Аж ахуй нэгжид ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар болон ноос бэлтгэл, үйлдвэрлэлийн зориулалтаар олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх.
100	3.3.20. Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох	70	Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих хүрээнд тэжээлийн түүхий эдийн тариалалтыг нэмэгдүүлэх, тэжээлийн таримал ургамлын үрийн шинэ сорт бий болгох, бүртгэх зорилгоор "Таримал ургамлын шинэ сортыг нэрлэх" журам, "Сортыг бүртгэх, бүртгэлээс хасах" журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/183 дугаар тушаалаар батлуулсан байна. Ингэснээр шинэ төрлийн тэжээлийн таримлыг бий болгож, дотоодын тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих боломж бүрджээ.	Холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг батлуулах
101	3.3.18. Газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэхэд мах, сүүний цэвэр үүлдрийн өсвөр үхрийг өсгөн үржүүлэх, худалдан авч иргэн, аж ахуйн нэгжүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлээр олгох. Малын тэжээлийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих. Малын тэжээл тариалагч иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хөнгөлөлт үзүүлэх	50	1."Эрүүл хүнс-Малчны хотноос" хөтөлбөрийн хүрээнд Архангай аймагт улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 430 толгой Сэлэнгэ үүлдрийн үхрийг нийлүүлж, махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй 9 иргэн, аж ахуй нэгжид түрээсийн гэрээгээр олгов. 2.Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Говь-Алтай аймагт улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 160 толгой үржлийн сарлаг нийлүүлж, тус аймгийн сарлаг бүхий сумдын сарлаг үхрийн чанар, үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, 8 малчин өрхөд түрээсийн гэрээгээр олгов. 3. Мөн дээрх төслийн хүрээнд улсын төсвийн 300.0 сая төгрөгийн санхүүжилтээр Төв аймагт мах-ноосны чиглэлийн Эдельбаев үүлдрийн 60 толгой өсвөр хуц нийлүүлэх ажлыг зохион байгуулав. 4. ЭМАА эрхлэгчдийг дэмжих, малчид, мал аж ахуй эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлэх зорилгоор өндөр ашиг шимт мах, сүү, сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт үхрийн 11.0 мян.тун, мах-ноосны чиглэлийн хонины 3.0 мян.тун, нийт 14.0 мян.тун гүн хөлдөөсөн үр, 12 төрлийн ороо идэвхижүүлэгч, үр шингэлэгч бодис, шингэн азотын цехийн шүүлтүүр, хөргөлтийн мотор, усны сав зэргийг улсын төсвийн 725.0 сая төгрөгийн санхүүжилтээр импортлож, МҮСҮТөвд хүлээлгэн өгөв. Үүний үр дүнд 12.8 мянган бод, 4.5 мянган бог, нийт 17.3 мянган малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалт 72 хувьтай байна. 5. АДРА ОУБ-ын 47.0 мянган ам.долларын / 160.0 сая төгрөгийн/ санхүүжилтээр Авсралын үндэсний генийн сангаас ноосны чиглэлийн 5 үүлдрийн хуцны 6.0 мянган тун үрийг импортлож, генийн сангийн баяжилтыг хийв. 6.Малын тэжээл тариалагч иргэн, ААН-ийг дэмжих зорилгоор Тэжээлийн тогтвортой менежмент төслийн хүрээнд Дархан-Уул, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ аймгуудад тэжээлийн ургамал тариалах сургалт зохион байгуулж, 5.0 мянган тн үрийн дэмжлэг үзүүлэв. 7."Түмэн шувуут" ХХК, "Ажигана" ХХК-ийн тэжээлийн үйлдвэрлэлд зориулж жилийн хугацаатай 3 хувийн 12 тэрбум, Хөвсгөл аймагт хадлангийн 728.0 сая төгрөгийн 4 иж бүрдлийг тус тус олгосон байна.	Мах, сүүний цэвэр үүлдрийн өсвөр үхрийг зээлээр болон түрээсийн гэрээгээр олгох тоог нэмэгдүүлэх, малын тэжээл тариалагч иргэн, аж ахуй нэгжид олгох зээл түүний хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч боломжийг судлан хэрэгжүүлэх.
102	3.3.14. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх	30	ГХАН, БНХАУ-ын эрх бүхий байгууллагатай хамтран 2022.10.27-ны өдөр зохион байгуулсан "GIZ-CIQA Хүйтэн хэлхээний менежмент ба Хятад Улсын мах, махан бүтээгдэхүүний импорт" сэдэвт сургалт, уулзалтад экспортологч 19 аж ахуйн нэгжийг хамруулсан. "Стратегийн хүнсний экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын дагуу Монгол Улсын 2022 оны 10 дугаар сараас 2023 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд экспортлох, импортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээний саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Зөвлөмж гаргуулсан. 4.ХХААХҮС-ын 2022 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 тоот тушаалын хүрээнд БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүн экспортыг сэргээх ажлыг эрчимжүүлж, ажлын хэсгийн төлөвлөгөөг батлан ажиллаж, БНХАУ-ын эрх бүхий байгууллагын импортын мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, баталгаажуулах талаар тавьсан шаардлагыг бүрэн хангаж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай "нэмэлт гэрчилгээ"-ний загварыг тохирсны үндсэн дээр 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс Эрээн боомтоор мах, махан бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн. Монгол Улс 2018 онд 70.4 мян.тн, 2019 онд 58.6 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон ба Дэлхийн нийтийн хамарсан Короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас дээрх тоо хэмжээ 45% буурч 2020 онд 38.8 мян.тн, 2021 онд 21.8 мян.тн, 2022 оны 11 сарын 17-ны өдрийн байдлаар 6.4 мян.тн мах, махан бүтээгдэхүүн тус тус экспортолсон байна.	Мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг судалж, экспортыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, экспортлох махны хэмжээг нэмэгдүүлэх талаар судалж арга хэмжээ авах.
103	3.3.15. Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх	30	"Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Италийн талтай хамтран цэвэрлэх байгууламжийн ерөнхий схемийг боловсруулан, шаардагдах тоног төхөөрөмжүүдийн тооцоо судалгааг гарган, ТЭЗҮ-д тусгасан. ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу "Цэвэрлэх байгууламжийн барилгын зураг төсөв боловсруулах" зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Чанарын түншлэл" ХХК шалгаран, 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн ДАШЦББТӨХХК/202206019 дугаартай гэрээг Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК-тай байгуулан ажлыг эхлүүлсэн. Цэвэрлэх байгууламжийн зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд усан сангийн барилгын бүтэц, барилгын архитектурын ажлын зураг хийгдэж дууссан бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын гэрээний хугацааг гүйцэтгэгч компанийн хүсэлтийн дагуу сунгаад байна.	Гэрээнд заасан хугацаанд "Цэвэрлэх байгууламжийн барилгын зураг төсөв боловсруулах" ажлыг дуусгахад анхаарах.
3.4. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.				

104	3.4.9. "Гандангийн дэнж" шинэ аялал жуулчлалын төвийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх	75	"Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулиар "Гандангийн дэнж" шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажилд 590.0 сая төгрөг батлагдсан байна. Тус ажлын төндөрийн баримт бичгийг боловсруулан 2022 оны 11-р сарын 11-ний өдөр дахин зарлан 2022 оны 12-р сарын 12-ны өдөр нээсэн байна. Багц 1 "Гадна дулаан, цэвэр ус, ариутгах татуурга, зам талбайн тохижилт, Мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга угсралтын ажил" Бумбод" ХХК; Багц 2 "Гудамж дундын чулуун замын зураг төсөв, гүйцэтгэл" Фючерпрогресс ХХК шалгарч зөвлөмж хүргүүлэх шатанд явж байна.	Төндөрт шалгарсан аж ахуй нэгжтэй хамтарч ажиллах, гэрээнд заасан хугацаанд барилгын ажлыг эхлүүлэх ажлыг эрчимжүүлэх.
105	3.4.1. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий, "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II"-ыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хэрэгжүүлэх	70	"Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг Хөвсгөл, Хэнтий аймгуудад хэрэгжүүлэх хүрээнд 1.Хөвсгөл аймагт 3 чиглэлийн 37.9 км авто зам, 7 авто зогсоолын барилгын ажил 22%, 2.Хөвсгөл нуурын БЦГ-т 15 км явган болон морин аяллын жимийн тохижилтын зураг төсөл боловсруулагдсан. 3.Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Хэнтий аймгийн Дадал суманд хатуу хог хаягдлын ландфилл байгууламжийн барилгын ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажил Дадал суманд 72 %, Хатгал тосгонд 80 %. 4.Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх суманд Бохир ус цэвэрлэх байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх гэрээг "Хаанзаа" ХХК-тай байгуулж ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажил Хатгал тосгонд 95 %. 5.Хөвсгөлийн УТХГ-ын "Хамгаалалтын захиргаа/ жуулчны мэдээллийн төв"-ийн барилгын зураг төсөл боловсруулах ажил 70 %. 6.Ханх сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 95 %. 7.Хэнтий аймгийн Дадал суманд баригдах "Чингис хаан" АЖК-ын Мэдээллийн төвийн барилга, орчны тохижилт, бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, бараа нийлүүлэлтийн ажил"-ыг нэг багц төндөр зарлагдаад гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан. 8.Дадал сумын ЗДТГ-аас ирүүлсэн 7 саналд үндэслэн 4-н ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд ажлын гүйцэтгэл 57.5 %. 9.Дадал сумын аялал жуулчлалын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулсан. 10.ХНБЦГ-ын Менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ТХБНУГ-аар батлуулсан. 11.Хөвсгөл нуурыг хамгаалах эргүүлийн 2 завь худалдаж авах гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Хөвсгөл аймаг 4, Хэнтий аймагт 2 бүтээн байгуулалтын ажил 50%. Монгол Улсын Ерөнхий сайдын 106 дугаар захирамжаар "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II"-ыг санхүүжүүлэхэд зориулсан Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк хоорондын зээлийн хэлэлцээр батлагдсан.12 дугаар сард багтаан УИХ-аар соёрхон батлуулахаар хуулийн үзэл баримтлалыг батлуулна. Бүтээн байгуулалтын ажлуудын зураг, төсөв батлагдсан.	Тус аймгуудад ажил гүйцэтгэх гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гэрээ байгуулагдсан ажлыг хийж гүйцэтгэхэд анхаарах.
106	3.4.2. "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор"-ын ажлуудыг цогц байдлаар дуусгаж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах	70	1.Хэнтий аймгийн Норовлин сумын "Шихихутаг-Их засаг" цогцолборын ажлын хүрээнд дараахь 5 багц ажлууд хийгдэж байна. Үүнд: 1.Барилга угсралтын ажил-75%, 2. Гадна цахилгаан гүйцэтгэл-100%, 3. Гадна шугам сүлжээний ажил-100%, 4. Гадна тохижилтын ажил-65%, 5. Барилгын дотор интерьер-30%, 5 багц ажлын гүйцэтгэл 70% байна. 2. "Их хуралдай" цогцолборын гадна тохижилтын ажлыг "Нутгийн баруун мод" ХХК, зоорийн ажлыг" Мөнх өргөө" ХХК тус тус хариуцан гэрээ байгуулан ажиллаж байна. Их хуралдай цогцолборын ажлын гүйцэтгэл: 1. Газар тэгшилсэн 90% 2. Картограмм ажил букуу 3200м3 шороо зөөх ажил 70% 3. 78ш гэрлийн шон цутгах ажил 100% дууссан 4. Гадна гэрэлтүүлэг монтажийн ажил 90% 5. Худаг гаргах ажил 100% 6. Худаг, харуулийн байр-70% . 7. Гэрэлтүүлгий ажил 80% 8. Гадна хашаа барих ажил 90% тус тус хийгдээд байна Нийт гүйцэтгэл 80%-тай байна.3 Монголын нууц товчоо цогцолборын үндсэн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг БОАЖЯ Хасу мегаватт ХХК-тай 2020.05.18-2022.11.10-ны хооронд 1,583.6 сая төгрөгөөр хийхээр байгуулсан. Нийт 1,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гадна тохижилтийн ажлын талаар: Монголын нууц товчоо цогцолборын гадна тохижилт, интерьер, халаалт салхивч, холбоо ажил гүйцэтгэх гэрээг ДИ ЭС ТИ ХХК-тай 2022.10.17-2023.08.31-нд хийхээр 566.5 сая төгрөгөөр байгуулсан.	Гэрээ байгуулагдсан ажлын явцыг хурдасгах, гэрээнд заасан хугацаанд хийж дуусгахад анхаарах.
107	3.4.4. Олон улс, улсын чанартай авто замын дагуу түр зогсох талбайг 100 км тутамд барьж байгуулах ажлыг эхлүүлэх	70	Завхан аймгийн Сонгино, Архангай аймгийн Цэнхэр, Булган аймгийн Хутаг өндөр, Төв аймгийн Баянцагаан, Хэнтийн аймгийн Жаргалтхаан суманд авто замын дагуу үйлчилгээний цолцолборыг барьж 2022 онд ашиглалтад оруулсан байна. "Аялал жуулчлалын гол чиглэл, олон улс, улсын чанартай авто замын дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл"-ийг хамтран хэрэгжүүлэх гэрээг МХАУТ-аас 14 компанитай байгуулсан. Нийт 19 байршилд 9 тэрбумын хөрөнгө оруулалтаар 12 сарын хугацаанд барьж гүйцэтгэхээр гэрээнд тусгасан байна.	Гэрээ байгуулсан аж ахуй нэгжүүд гэрээнд заасан хугацаанд түр зогсох талбайг барьж дуусгахад анхарах.
108	3.4.5. НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх	70	НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран цар тахлын дараа аялал жуулчлалын салбарыг сэргээх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэрээний төлбөр цар тахлаас үүдэлтэй хугацаандаа хийгээгүй тул ажлыг НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага хийхгүй болохоо илэрхийлсэн. Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан "Монгол Улсын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө"-г 8 зорилт 28 дэд зорилттойгоор боловсруулж, Ерөнхий сайдын дэргэд байгуулагдсан Аялал жуулчлалын үндэсний хорооны 10 дугаар сарын 27-ны хуралдаанд танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор БНСУ-ын жуулчдыг визийн шаардлагаас чөлөөлсөн шийдвэрийг гарган, энэ оны хувьд аялал жуулчлалын голлох зах зээлийн орныг Азийн орон гэж тодорхойлсон ба тус зорилтын хүрээнд Монгол Улсын зорин ирж аялсан Солонгос жуулчдын тоо 50 мянгад хүрсэн ба 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр олон улсад хилээ нээсэн зарласнаас хойших 9 сарын хугацаанд Монгол улсад ирсэн жуулчдын тоо 240 мянгад хүрсэн байна.	НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллах ажлыг эрчимжүүлж, Монголд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх.

109	3.4.8. Аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг идэвхжүүлэх	70	БОАЖЯ,НАЖГ, МАЖХ-ноос "МИАТ" ХК, "Аэромонголиа" ХХК, "Говь" ХК-иудын дэмжлэгтэйгээр Токио, Осака,Сөүл, Бусан хотуудад Монгол Улсыг сурталчлах "Монголын аялал жуулчлалын форум"-ыг нэгэн зэрэг зохион байгуулж, нийт 143 аж ахуйн нэгжийн төлөөлөл, БНСУ-ын Сөүл, Пусан хотуудад зохион байгуулагдсан форумд БНСУ-ын аялал жуулчлалын 101 аж ахуйн нэгжийн төлөөлөл, нийт 244 аж ахуйн нэгж оролцсон байна. 2022.06.21-ний өдөр гадаадын 6 хэл дээр Монгол Улсын сурталчлан таниулах дижитал сэтгүүлийг цахим платформ болгон олон улсад сурталчлах ажлыг МАЖХ ТББ-тай хамтран зохион байгуулсан байна. Япон Улсын Жата ОУ-ын үзэсгэлэн, Францын соёлын өдрүүд арга хэмжээнд 60 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн оролцлоо. 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсыг гадаадад сурталчлах mongolatravel.guide цахим платформ нээлтээ хийж, уг цахим платформмыг олон нийтэд сурталчлах Монгол Улсад суугаа элчин сайд, төлөөлөгчийн газарт албан бичиг явуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Гадаад харилцааны яам хамтран Монголын соёлын өдрүүд олон улсын үзэсгэлэнг Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод 9 дүгээр сарын 20-ноос 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. "JATA-2022" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн Япон улсын Токио хотод 2022 оны 09 сарын 22-25ны өдрүүдэд зохиогдсон тус арга хэмжээнд АЖХ хариуцан ажиллаж, БОАЖЯ, НАЖГ азар, МИАТ ТӨХК хамтран оролцож дэмжин ажилсан. Монголын аялал жуулчлалын "АЙТИЭМ" олон улсын үзэсгэлэн 2022 оны 10 дугаар сарын 28-30өдрүүдэд зохион байгуулагдсан. БОАЖЯ 21 аймгийн аялал жуулчлалын газрууд, аялал жуулчлалын холбоод оролцсон байна.	Аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилах зорилгоор цахим платформуудыг олноор хийж түгээх.
110	3.4.7. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, дэд бүтцийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн дотоодын болон гадаадын аялагч, жуулчдын тоог нэмэгдүүлэх	60	Баян-Өлгий аймгийн Улаанхус, Цэнгэл суманд Алтай таван богд Байгалийн цогцолбор газарт "Альпиниад-2022" их наадам, "Бүргэдийн баяр", Хөвсгөл аймагт "Хөх сувд" мөсний баяр, "Цаатангуудын баяр, Булган аймгийн Орхон сумын "Өрмийн цагаан нуур"-ын эрэгт "Айргийн баяр" арга хэмжээ, Ховд аймгийн Мөст суманд Захчин түмний өв соёлыг сурталчилсан "Тонжоо" наадам, Өмнөговь аймагт "Тэмээний баяр", "Элсэн манхны баяр", Төв аймагт "Хонины найр", "Төр түмний цэнгэл" баяр наадам, Улаанбаатар хотод "Дээлтэй монгол" наадам, "Хүрээ цам" даншиг наадам, "Нүүдэлчин Монгол" наадам, "Наадам найт" арга хэмжээ, Плэй тайм арга хэмжээ, Өвөрхангай аймагт "Сарлагийн баяр", "Монгол эсгий урлалын баяр", "Монголын уламжлалт биет бус өв соёл дэмбээ наадгай", "Адууны өв соёлын баяр", спорт аялал жуулчлалыг дэмжсэн " UJ спорт фестивал", " Хаадын хаан - Чингис хаан " НҮБ -ийн төлөөлөгчдөд зориулсан морин шоу үзүүлбэр, АйТиЭм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Шинэ сэргэлт ба Аялал жуулчлал 2022, Хаадын хаан морин шоу олон улсын төлөөлөгчдөд зориулсан арга хэмжээ, Хорека Монголиа 2022 зочлох үйлчилгээний үзэсгэлэн, Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойд зориулсан "Зүүн бүсийн аялал жуулчлалын зөвлөгөөн" арга хэмжээ, "Талын түмэн адуу" нийт 30 гаруй арга хэмжээнд 90 сая төгрөгийн санхүүгийн болон удирдлагын дэмжлэг үзүүлжээ. Дорнод аймгийн аялал жуулчлалын зөвлөгөөн, Өмнөговь амийгийн Тэмээн соёл, аялал жуулчлал хөгжүүлэх бүсийн зөвлөгөөнүүдэд оролцож Монголд зочлох жил болон бодлогын үйл ажиллагааг танилцуулсан. 2022 онд 17 цэгт отоглох цэгийг байгуулахаар төлөвлөснөөс 9 отоглох цэг баригдсан үлдсэн 8 отоглох цэг ЗГ-ын хэмнэлтийн хуулиар хойшлогдсон байна.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, гадаадын болон дотоодын аялагч, жуулчдыг сонирхлыг татах үйл ажиллагааг эрчимжүүлэх.
111	3.4.3. Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилгын ажлыг эхлүүлж, ажлын явцыг 80 хувьд хүргэх	50	Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах хүрээнд: 1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, 2. Газрын инженер геологийн дүгнэлт гаргуулах, 3. Барилгын дэвсгэр зураг боловсруулах, 4. Архитектур төлөвлөлтийн даалгавар авах, 5. Сургалтын төвд цэвэр, бохир, ус холбогдох асуудлыг шийдвэрлэх, 6. ТЭЗҮ, зураг, төсвийг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраар батлуулах ажлыг гүйцэтгэж барилгын зураг төслийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-аар магадлангаар оруулж батлуулав. БНСУ-д 2022 оны 04 дүгээр сарын 8-ны өдөр Барилгын ажлыг гүйцэтгэх зөвлөх сонгон шалгаруулах тендерийг зарлаж БНСУ-ын Чон Үк Корпораци шалгарч гэрээг байуулсан байна. 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр барилгын суурийн ажлыг эхлүүлсэн. Барилгын ажил төлөвлөсний дагуу хэрэгжин өвлийн дулаалгын хучилтаа хийгдсэн. 11 сарын 20-ны өдрөөр барилгын ажлын зогсоож дотоод зохион байгуулалтын ажлаа явуулж байна. Барилга угсралтын явц 10 хувьтай байна.	Барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд чанарын түвшинд хийж гүйцэтгэхэд анхаарах
112	3.4.6. "Цайны зам" хил дамнанас аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлэх	50	"ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд ""Цайны зам""-ыг бүртгүүлэх суурь судалгааны ажлыг Монголын аялал жуулчлалын холбоо ТББ-аар 30 сая төгрөгийн төсөвтэйгөөр гүйцэтгүүлж, тайланг хүлээн авч, төлөвлөлт хийсэн. Хил орчмын аялал жуулчлалын хөтөлбөр болон тур оператор компанид тавих шаардлагыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Өмнөговь аймаг дахь хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад ажиллаж, 72 цагийн жуулчдыг нэвтрүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн боломжийг нягтлан шалгаж, шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх санал боловсруулж, дэд бүтцийн нөхцөлийг сайжруулах ажлыг тодорхойлов. Мөн хоёр талын аялал жуулчлалын байгууллагуудад ойлгомжтой хилээр нэвтрэх процессыг зураглан БНХАУ-ын хил нээгдэх үед хил орчмын жуулчин авах бэлтгэлийн хүрээнд гарын авлага боловсрууллаа. Монгол, Орос, Хятад Улсуудын аялал жуулчлалын сайд нарын 7 дугаар хуралдааныг цахимаар зохион байгуулах тухай БНХАУ-ын Соёл, Аялал жуулчлалын сайд Ху Хэпинээс ирүүлсэн захидлыгт хүлээн авч,"Их цайны зам"-ийн үйл ажиллагааны 7 дугаар төсөлд БОАЖСайдын 01/6838 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын виз олгох журам шинэчлэгдэж хил орчмын жуулчдад 72 цагийн виз олгох эрх зүйн орчин бүрдсэн. Засгийн газрын хуралдааны 5 дугаар сарын 4, 11-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр хилийн боомт дээр цахимаар виз олгох мэдээлэл сурталчилгааны цогц ажлыг шийдвэрлүүлсэн. Монгол, Буриад хоёр улсын төлөөлүүд хамтарч Байгаль нуур-Хөвсгөл нуур чиглэлийн маршрутыг хэлэлцэн батлав.	НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллах ажлыг эрчимжүүлж, Монголд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх.
3.5. Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.				
113	3.5.6. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийг /салхины цахилгаан станцын 2 төсөл 15 МВт, нарны цахилгаан станцын 4 төсөл 35 МВт/ хэрэгжүүлэх	90		Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

114	3.5.9. Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлэх /Эрчим хүчний төсөл-2/	95		Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
115	3.5.14. Шинэ нисэх-Зуунмод сумыг холбосон 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц байгуулах	90		Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
116	3.5.12. Газрын гүний дулааны эх үүсвэрийг ашиглах загвар төслүүдийг хэрэгжүүлэх	70		Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
117	3.5.3. Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	66.6	Шийдвэрүүд гарсан. Төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан олон улсын нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч тендерт оролцсон компани тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд "Эрдэнэс тавантолгой" ХК-тай хувьцаа эзэмшигчдийн гэрээ, нүүрс нийлүүлэлтийн гэрээ байгуулагдсан. Хөрөнгө оруулалтын гэрээ, санхүүжилтийн гэрээний төслүүдэд 2 талаас хамтран ажиллаж байна. Төслийн нийт хэрэгжилт 10 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
118	3.5.2. Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх	58.6	БНХАУ-ын 0 ковид бодлогын хүрээнд хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн горимд орохгүй байгаагаас төслийн бараа материал, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт удаашралтай байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 300 гаруй машин тоног төхөөрөмж үйлдвэр дээр, 120 гаруй машин тоног төхөөрөмж БНХАУ-ын Эрээн хотод тээвэрлэгдэн ирсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 58.3 хувьтай байна.	Үйл ажиллагаанд учирч болох бусад эрсдэлийг тооцох
119	3.5.5. Чойр-Сайншанд чиглэлийн 230 км урттай, 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих ажлыг эхлүүлж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх	30	Төслийн зээлийн гэрээний хэлцэл амжилттай хийгдэж, зээлийн гэрээнд ЕСБХБ, МУ-ын Сангийн яам гарын үсэг зурсан. "Төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг байгуулах тухай саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Төслийн БУА-ын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтуудыг банкны шаардлагын дагуу боловсруулах "Хувь зөвлөхүүд"-ийг төслийн техникийн туслалцааны хүрээнд авч ажиллуулах саналтай байгаагаа тус яамны зүгээс ЕСБХБ-д хүргүүлсэн.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
120	3.5.7. Багануурын 400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	30	Багануур Плаур" ХХК-ийн хувьцаа эзэмшигч БНХАУ-ын "Цөмийн аж үйлдвэрийн барилга" ТӨХК-иас тус улсын "нүүрсний станцуудад хөрөнгө оруулалт хийх болон хүлэмжийн хийн ялгаруулалт ихтэй төслүүдийг дэмжихгүй байх" төрийн бодлого, шийдвэртэй холбогдуулан хувьцаагаа шилжүүлэх албан хүсэлтийг 2022.08.01-ний өдөр МУ-ын ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Энэхүү асуудал шийдвэрлэгдэх хүртэл төсөл үргэлжлэх хугацаа тодорхойгүй байдлаар хойшилж байна.	Үйл ажиллагаанд учирч болох бусад эрсдэлийг тооцох
121	3.5.13. Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	30	Төслийн БОННУ-ний судалгааг хийж байгаа Төслийн ТЭЗҮ, зураг төслийг 2022.09.15-ны өдрийн а/3490 тоотойр СЯ-нд хүргүүлсэн. АХБ-ны зүгээс төслийн зээлийн гэрээг 2023 оны 09 дүгээр сард батлуулах төлөвлөгөөтэй байна. Төслийн ХАА-ны төлөвлөгөөг боловсруулж байна. Судалгааг шуурхай хийх	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
122	3.5.8. 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих	25	Дэлхийн зах зээл дээрх цэнэг хураагуурын түүхий эдийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан тендер ирүүлсэн компаниуд үнэ нэмэх нөхцөл тавьж, АХБ-ны зөвлөмжөөр эхний тендер хүчингүй болж, дахин зарлагдсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын ZTT-ZEST консорциум шалгарч, 2022 оны 7 дугаар сард гэрээнд гарын үсэг зурсан ба АХБ-ны зөвлөмжийн дагуу гэрээнд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Барилга угсралтын ажлыг 2022.08.04-ний өдөр эхлүүлсэн ба төслийн ажлын зураг хийгдэж байна. Төслийн нийт хэрэгжилт 20.0 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
123	3.5.10. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг эхлүүлэх	20	төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийн баримт бичгийг боловсруулж 2022.11.04-ний өдөр төслийн санхүүжүүлэгч Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-д хүргүүлж "Үл татгалзах зөвшөөрөл" авах хүсэлт гаргасан. KfW банк тендерийн баримт бичгийг хянаж, шалгах ажил хийгдэж байна. Төслийн нийт хэрэгжилт 10 хувьтай байна. Бэлтгэл дутуу	Шийдвэр гаргалтыг хурдасгах, санхүүжилтийг шийдвэрлэх
124	3.5.11. Тайширын УЦС-аас Есенбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих	20	Цар тахалтай холбоотойгоор тулгуурын захиалга болон нийлүүлэлт оройтсон мөн ажлын зурагт өөрчлөлт орох болсон зэрэг шалтгааны улмаас тус төслийн ажил удааширсан бөгөөд төслийн БУА-ыг 2022 оны 06 дугаар сард эхлүүлсэн. Төслийн хүрээнд баригдах 110/35/6 кВ-ын 10 МВт-ын хүчин чадалтай дэд станцын газрыг өөрчилж дахин геодезийн дүгнэлт хийлгэж, шинээр газар сонгон талбайг тэгшилж дэд станцын барилгын суурийн ажлыг эхлүүлсэн. Шугамын болон бусад тоног төхөөрөмжүүдийг 100 хувь захиалсан, дэд станцын газар шорооны ажлууд хийгдсэн. Станцын газардуулга болон хашаа барьсан. Дэд станцын тоноглолын суурь УСО босгож дуусгасан. 110кВ-ын ЦДАШ-ын тулгуур гагнах, тулгуурын ажил хийгдэж байна. Төслийн хэрэгжилт 20 хувьтай байна.	Үйл ажиллагаанд учирч болох бусад эрсдэлийг тооцох
125	3.5.15. Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийг найдвартай эрчим хүчээр хангах ажлын хүрээнд эрчим хүчинд холбогдоогүй үлдсэн 8338 өрхийг эрчим хүчинд үе шаттайгаар холбох	90	10.3.5.15-д тусгагдсан "Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийг найдвартай эрчим хүчээр хангах" ажлын хүрээнд эрчим хүчинд холбогдоогүй үлдсэн 8,338 өрхийг эрчим хүчинд үе шаттайгаар холбох төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газраас 100 хувиар үнэлснийг санхүүжилт бүрэн шийдвэрлэгдсэн хэдий боловч дэвшүүлсэн зорилтдоо бүрэн хүрээгүй, үйл ажиллагаанд шаардлагатай зарим барилгын ажлыг эхлүүлсэн байдалтай байгаа тул тус арга хэмжээг 90 хувийн хэрэгжилттэй гэж тус тус бууруулж үнэллээ.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
3.6. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.				
126	3.6.5. Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замыг барих ажлыг эхлүүлэх	90	Цементийн хомсдоллоос шалтгаалан зам барилгын ажил удааширсан. Барилгын ажлын гүйцэтгэл 63.0 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
127	3.6.3. Улаанбаатар төмөр замын 50 км гол замд их засвар хийх	88.6	2021 онд төлөвлөсөн 50 км төмөр замаас гадна нэмэлттээр 30.7 км төмөр замын их засварын ажил гүйцэтгэсэн ба 2022 онд 6.8 км /Эмээлт зөрлөгийн 2.3 км замын сунгалтын ажил, Цомог зөрлөгт 4.5 км замын сунгалтын ажил/-т их засварын ажил хийв. Нийт 44.3 км төмөр замын их засварын ажил гүйцэтгэсэн.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

128	3.6.6. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 136 км авто зам, Орхон голын төмөр бетон гүүрийг барих	78.5	Төслийг хэрэгжүүлэхэд 2022 онд 10.1 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 6.1 тэрбум төгрөг болсон. Үлдэгдэл хөрөнгө 2023 оны төсөвт тусгасан. Тодотголоор хасагдсан дүнтэй уялдуулан ажлын барилгын ажлын хүрэх түвшингийн хувийг шинэчлэхгүй бол хөрөнгөөс шалтгаалан барилгын ажил зорилгот түвшинд хүрэх боломжгүй нөхцөл үүссэн. Орхон голын 220 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажил дуусаж, хөдөлгөөн нээсэн ба гүүрийн 2 талын 3 км авто замын далан, хөдөлтөөс хамгаалах үе, суурийн доод үеийн ажлууд хийгдэж дууссан. Барилгын ажил 78.5 хувьтай. Батлагдсан хөрөнгийг бүрэн зарцуулсан.	Санхүүжилтийг шийдвэрлэх
129	3.6.7. Багануур хотоос Төв аймгийн Мөнгөнморьт сум хүртэл 60 км хатуу хучилттай авто замыг барих	76.8	2022 онд 6.4 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 3.8 тэрбум төгрөг болсон. Улсын төсөвт хөрөнгө багаар тусгагдаж, санхүүжилтээс шалтгаалан барилгын ажил товчлосон хугацаанд дуусах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна. Батлагдсан төсөвт өртөгөөс 12 тэрбум төгрөг дутуу. Тус авто замын барилгын ажил гүйцэтгэх 2022 оны график төлөвлөгөө батлуулсан ба нэмэлт гэрээ байгуулах ажил баталгаажсан. Талбайд өөрийн шуудуу болон сум доторх явган замын ажил хийгдэж байна. БУА 76.8 хувьтай. Бараа материал, түлшний үнэ батлагдсан төсвөөс 2-оос 3 дахин өссөн тул барилгын ажил хийгдэх боломжгүй төсөвт дахин магадлал хийх шаардлагатай талаар гүйцэтгэгч хүсэлт ирүүлж барилгын ажлыг түр зогсоогоод байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
130	3.6.16. 4 улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулж, 1 улстай нислэгийн цэг, давтамжийг нэмэгдүүлсэн байх	70	"Агаарын харилцааны тухай" МУ-ын ЗГ, Бүгд Найрамдах Узбекистан Улсын ЗГ хоорондын хэлэлцээрт Гадаад харилцааны Дэд сайдын 2022 оны 06 дугаар сард БНУЗУ-д хийх албан ёсны айлчлалын үеэр гарын үсэг зурж, байгуулах саналыг 2022.05.06-ны өдрийн 01/2120 тоот албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. "Агаарын харилцааны тухай МУ-ын ЗГ, Бүгд Найрамдах Латви Улсын ЗГ хоорондын хэлэлцээр"-ийн төслийг эцэслэн тохирч, Агаарын харилцааны хурал (ICAN 2022)-ын дараа 12 дугаар сард багтаан үзэглэхээр тохиролцсон. "Агаарын харилцааны тухай" МУ-ын ЗГ, Бүгд найрамдах Словени Улсын ЗГ, Бүгд Найрамдах Итали Улсын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг Словени, Италийн талд тус тус уламжлуулахаар 2022.05.04-ний өдрийн 01/2035 тоот албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. ГХЯ-аас хэлэлцээрийн төслийг 2022.05.11-ний өдрийн цахим шуудангаар Вена дахь ЭСЯ-нд илгээсэн. -Америкийн талтай эцэслэн тохиролцсон "Агаарын тээврийн тухай МУ-ын ЗГ, АНУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч тусган, 2022.11.30-ны өдрийн 01/5529 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Грекийн талтай үзэглэсэн Агаарын харилцааны хэлэлцээрийн төслийн монгол хэл дээрх албан орчуулгыг хянан баталгаажуулж, Грекийн талд дипломат шугамаар хүргүүлэх хүсэлтийг ГХЯ-д хүргүүлсэн. Нислэгийн цэг, давтамж нэмэгдүүлэх: Монгол-Япон хоорондын нислэгийн давтамж долоо хоногийн 13.5 нэгж буюу 13 хүртэлх давтамж, үүнээс 7 давтамж нь Улаанбаатар-Токио чиглэлд ашиглагдаж байсныг 7 хоногийн 9000 суудлын багтаамж, 30 хүртэлх давтамж болгон нэмэгдүүлсэн. Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар чиглэлд томилогдсон агаарын тээвэрлэгчид Солонгосын талаас долоо хоногт 3 удаагийн хуваарьт нислэгийн зөвшөөрөл олгож байсныг 2022 оны 05 дугаар сард 7 болгон нэмэгдүүлсэн. Хятадын талын цар тахлын хязгаарлалтаас шалтгаалан хоёр улсын хооронд 14 хоногт 2 тал 1, 1 удаа нислэг гүйцэтгэж байсныг 7 хоногт 2 тал тус бүр 3 удаа болгон нэмэгдүүлсэн. Ачаа тээврийн нислэгийн давтамжийг 7 хоногт 7 болгон нэмэгдүүлсэн. Хариу хүлээж байгаа	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
131	3.6.18. Орон нутаг дахь ашиглагдахгүй болсон нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас, талбайг сэргээн сайжруулж, ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах	70	Орон нутагт нийт 59 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасын талбайг сонгон баталгаажуулсан. Мөн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Скай Резорт" ХХК-ийн цанын бааз, "Интермед" эмнэлэгт нисдэг тэрэг хөөрч, буух талбайн /вертодром/ үзлэг шалгалт хийж мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан. 2022.12.14-ний өдрийн байдлаар ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах бага оврын агаарын хөлөг хөөрч буух түр зурвас талбай 13 аймгийн 55 байршилд цэг сонгосон ба 4 аймгийн 7 байршилд цэг сонгоогүй үлдээд байна. Мөн бага оврын агаарын хөлөг хөөрч буух түр зурвас талбайг Хөвсгөл аймгийн Ринчэнлхүмбэ суманд эхлүүлсэн, Ховд аймгийн Чандмань суманд байгуулан хүлээн авсан.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
132	3.6.2. Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх	60	Тус чиглэлийн авто замын барилгын ажлын явцын талаар танилцуулга бэлтгэн, 2022.03.09-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2022.03.10-ны өдөр концесс эзэмшигч, гүйцэтгэгчийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, зам барилгын ажил гүйцэтгэхэд учирч буй саад бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг нь сонсож, мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэл өгсөн. Зам барилгын ажлыг 2022.03.15-ны өдөр эхлүүлсэн. Талбайд 819 хүн хүч, 582 машин, техник тоног төхөөрөмж байршин, хэмжилт, далангийн дүргэлт, суурийн доод үе, хиймэл байгууламж, чулуу бутлах ажил гүйцэтгэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 42 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
133	3.6.19. Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн 2 дугаар үе шатны барилгын ажлыг дуусгах	60	Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг 2022.03.15-ны өдрөөс эхлүүлсэн. Зам барилгын ажлын талбай дээр 380 гаруй инженер техникийн ажилчид, 250 орчим техник, тоног төхөөрөмж ажиллаж байгаа бөгөөд нийт 5 багц хэсгийн барилгын ажил Багц 1-1 хэсэг 96.16%, Багц 1-2 хэсэг 89%, Багц 1-3 хэсэг 99.5%, Багц 1-4 хэсэг 52.3%, Багц 1-5 хэсэг 99.9%-ийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна Төслийн ажил 82%-ийн гүйцэтгэлтэй байна. - Европын сэргээн босголтын банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн барилгын ажлыг 2022.03.15-ны өдрөөс эхлүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд 2022 онд барилгын ажлын талбай дээр 736 гаруй инженер техникийн ажилчид, 317 техник, тоног төхөөрөмж ажиллаж байгаа бөгөөд нийт 5 багц хэсгийн барилгын ажлын гүйцэтгэл Багц 1 хэсэг 85.7%, Багц 2 хэсэг 47%, Багц 3 хэсэг 45%, Багц 4 хэсэг 60%, Багц 5 хэсэг 62%-ийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна. Төслийн ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
134	3.6.10. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий-Хужирт-Арвайхээр чиглэлийн 101 км хатуу хучилттай авто замыг барих	50	2022 оны Улсын төсөвт Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай авто замыг барих 11.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 1.3 тэрбум төгрөг болсон. "Мотор сервис" ХХК Орхон голын 220 у/м гүүрийг барьж улсын комиссын №06/05/21 дүгээр дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Тодотголоор хасагдсан дүнтэй уялдуулан барилгын ажлын хүрэх түвшингийн хувийг шинэчлэхгүй бол хөрөнгөөс шалтгаалан барилгын ажил зорилгот түвшинд хүрэх боломжгүй нөхцөл үүссэн. 2022 оны батлагдсан төсөвт өртөгт магадлал хийлгэн 2023 оны МУ-ын улсын төсөвт тусгуулсан. Сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажил хангагдаж байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх

135	3.6.11. Олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулах	50	Олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах цэгийг цахимжуулах ажлын ТЭЗҮ-ийн судалгааг хийж Зөвлөхийг шалгаруулж, гэрээ байгуулсан. Судалгааны ажлын эцсийн шатны тайланг хүлээж авсан. - Нийслэл хотыг тойрсон Эмээлт, Налайх, Хоолтын төлбөр авах цэгт тээврийн хэрэгслийн дугаар таних камер, тоног төхөөрөмжийг суурилуулж, урьдчилж төлөх, төлбөр авах цэгээр нэвтрэх үед төлөх, дараа төлөх гэсэн 3 сонголтоор "Монрау" "Social pay" "Е-баримт" үйлчилгээг ашиглан цахимаар төлбөр авах үйл ажиллагааг нэвтрүүлсэн. - Орон нутагт байрлах бусад төлбөр авах цэгийн үйл ажиллагааг цахимжуулах ажлын ТЭЗҮ-ийн судалгааг хийж, 2022.08.03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж 302 дугаар тогтоол гаргуулсан. Цахим системийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төлбөр авах цэгүүдэд суурьлуулж програм хангамж холбох ажлыг үе шаттай хийж байна.	Шийдвэр гаргалтыг хурдавчлах
136	3.6.15. 3 аймгийн төвд зорчигч тээврийн авто буудал байгуулах	50	1. Улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд Орхон аймагт автобуудал барих төсөл хэрэгжиж байна. Автобуудлын барилга угсралтын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөний дагуу хоцрогдолгүй явж байна. 2. "Зорчигч тээврийн Ховд" ХХК нь компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 85 хувьтай, энэ онд багтаан ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна. 3. "Бүрд чандмань" ХХК Хэнтий аймгийн Хэрлэн сумд автобуудал, мөн "Өв хангамж групп" ХХК нь Говьсүмбэр аймагт автобуудал барих хамтран ажиллах гэрээг "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай байгуулсан. 2023 оноос барилгын ажил эхлүүлэхээр гэрээг байгуулаад байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
137	3.6.26. Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замыг барьж эхлүүлэх /Булган/	50	Булган аймгийн Орхон-Хишиг-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 31.08 км авто зам 2022 оны Улсын төсөвт 9.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч тодотголоор хасагдаж, 1.2 тэрбум төгрөг тусгагдсан. Тодотголоор хасагдсан дүнтэй уялдуулан барилгын ажлын хүрэх түвшний хувийг шинэчлэхгүй бол хөрөнгөөс шалтгаалан барилгын ажил зорилтот түвшинд хүрэх боломжгүй нөхцөл үүсэж байна. ТХААГ-аас гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, 2022.08.09 "РЭС" ХХК-тай гэрээ байгуулсан. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулиар төлөвлөсөн хөрөнгийг бүрэн зарцуулж, хөрс хуулах, зөөвөрөөр далан, тохиромжгүй хөрс зайлуулах, хиймэл байгууламж, тэсэлгээний ажил хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 7.2 хувьтай байна.	Санхүүжилтийг шийдвэрлэх
138	3.6.4. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааг чадавхжуулах хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх	30	Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2022.08.30-ны өдөр ГТХЗНТ-ийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ГТХЗНТ/202208001 дугаартай тендер зарлаж тус газрын 2022.10.18-ны өдрийн А-1/2331 тоот албан бичгээр барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх сонгон шалгаруулалтад "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер оролцогчоор шалгарсан "Эм Эс Эл" ХХК-тай тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан гэрээ байгуулах зөвлөмжийг ирүүлсэн. Төвөөс зөвлөх үйлчилгээний гэрээний төслийг боловсруулж 2022.10.28-ны өдөр ЗТХЯ, "Эм Эс Эл" ХХК, Койкагийн Монгол дахь суурийн төлөөлөгчийн газар хамтран гэрээ байгуулсан.	Шийдвэр гаргалтыг хурдавчлах, төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах
139	3.6.12. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх	30	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх талаар холбогдох судалгааг хийж зөвлөмж авахаар Цахим, хөгжил, харилцаа холбооны яам, Тагнуулын ерөнхий газарт 12/09 тоот албан бичгээр хүргүүлж. Зөвлөмжийг хүлээж байна. ЗХАБ-ын мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх талаар Дэлхийн банк, Ази, номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажиглагч байгууллага, БНСУ-ын Койка байгууллагад хүсэлт гаргасны дагуу тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн систем бий болгох 14 сая \$-ын төслийг 2023 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлээд байна. Мөн Ази, номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажиглагч байгууллага, нэгдсэн системийг бий болгох чиглэлээр чадавхийг сайжруулах төслийг хэрэгжүүлэхээр болсон. Тус төслийг эхлүүлэхээр БНСУ-ын талаас хүсэлт тавьсны дагуу төслийн хамтарсан судалгааг эхлүүлсэн.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
140	3.6.14. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг цэнэглэх сүлжээг шатахуун түгээх станц, үйлчилгээний газруудыг түшиглэн төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах	30	Энэхүү арга хэмжээг ЗТХС, 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгасан. Улсын хэмжээнд 20-60 квт-ын хүчин чадалтай цахилгаан автомашин цэнэглэх 25, өндөр хүчин чадалтай их багтаамжийн цахилгаан автобус цэнэглэх 11, автотээврийн хэрэгслийг хийгээр цэнэглэх станц 21 аймагт 80, Улаанбаатар хотод 54-г үйлчилгээнд ашиглаж байна. Нийслэлийн 8 байршилд шинээр өндөр хүчин чадалтай цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх 25 станц барих санхүүжилтийг 2023 оны Агаар, орчны бохирдлыг бууруулах сангийн хөрөнгөөс шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	Шийдвэр гаргалтыг хурдавчлах, төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах
141	3.6.30. Арц суурь-Шивээ хүрэн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах	30	Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор тус чиглэлийн төмөр замыг зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэхээр концессын зүйлийн жагсаалтад оруулсан. Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замыг төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн" ХХК байгуулан Концессын "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулах, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг "Монголын төмөр зам" ТӨХК-д даалгасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Монголын төмөр зам" ТӨХК-аас Төслийн тусгай зориулалтын компанид хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхол бүхий этгээдийг сонгон шалгаруулалт хийсэн. Оролцогч байгууллагаас шүүхэд гомдол гаргасан тул хүлээгдэж байна.	Төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах
142	3.6.31. Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих	30	2022 оны улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус яамтай хамтран хэрэгжүүлж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн 3 дугаар шатны хүрээнд Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих хөрөнгийн асуудлын хүрээнд АХБ-ны зүгээс төслийн өмнөх урьдчилсан судалгааг (РРТА) эхлүүлсэн. Зөвлөхөөр ХБНГУ-ын "Kocks consult GMBH" компани шалгарч судалгааны ажлыг эхлүүлсэн. Ажлын явцын талаар АХБ, ЗТХЯ, Зөвлөх компани хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг 2022.09.13-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдсан. Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлөөр хэлэлцэгдэж дэмжигдсэн.	Санхүүжилтийг шийдвэрлэх

143	3.6.32. Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	30	Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд хүргүүлсэн (2022.10.04-ний 01/4549). Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн.	Санхүүжилтийг шийдвэрлэх, шийдвэр гаргалтыг хурдасгах
144	3.6.33. Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	30	Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд 2022.10.04-ний өдрийн 01/4549 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн.	Санхүүжилтийг шийдвэрлэх, шийдвэр гаргалтыг хурдасгах
145	3.6.34. Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж, олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэх	30	Төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт СЯ-нд 2022.10.04-ний өдрийн 01/4549 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төслийг "зураг төсөл боловсруулах-шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх" төрлөөр концесс эзэмшигчид ашиглуулах техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, бэлтгэл ажлыг хангуулахаар ИНЕГ-т 2022.12.06-ны өдрийн 09/5622 тоот албан бичгээр хүргүүлсэн.	Санхүүжилтийг шийдвэрлэх, шийдвэр гаргалтыг хурдасгах
146	3.6.35. Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн 667 км төмөр замын төслийг эхлүүлэх	30	Зүүн чиглэлийн төсөлд "Ийст коридор рэйлрөүд" ХХК, "Бодь интернэшнл" ХХК-ууд сонгогдож, гэрээ байгуулах хэлэлцээр хийгдэж байна. Хилийн Бичигт-Зүүнхатавч боомтыг холбох төмөр замын техникийн асуудлыг Хятад талтай яриа хэлэлцээ хийхээр "Монголын төмөр зам" ТӨХК-ийг сонгож ЗГ-ын 2022 оны 446 дугаар тогтоол гарсан. Үүний үр дүнд хэлэлцээ хийх, техникийн шийдлүүд тодорхой болсоноор ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явцад эерэгээр нөлөөлөх юм. Тухайн төслийн Концессын гэрээний төсөл боловсруулж байна. Барилгын ажлын нээлтийг 2022 оны 07 дугаар сарын 02-нд хийж Ерөнхий сайд оролцсон.	Санхүүжилтийг шийдвэрлэх, шийдвэр гаргалтыг хурдасгах
147	3.6.9. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлэх	0	Улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Санхүүжилт шийдвэрлэгдээгүй	Санхүүжилтийг шийдвэрлэх
148	3.6.23. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннاران чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барих	0	Орон нутгаас авто замын зурвас газар эзэмшүүлэх зөвшөөрөл олгогдоогүйгээс зам барилгын ажил зогссон.	шийдвэр гаргалтыг хурдасгах
149	3.6.24. Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх	0	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт хасагдаж, 20.8 тэрбум төгрөг төлөвлөснийг 2.5 тэрбум төгрөг болгон баталсан.	Санхүүжилтийг шийдвэрлэх
150	3.6.25. Хэнтий аймгийн Норовлин-Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 124 км хатуу хучилттай авто замыг барих	0	2022 онд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 6 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, тендер амжилтгүй болсон.	Зохион байгуулалтыг сайжруулах
151	3.6.29. Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт боомт чиглэлийн тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх	0	Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр концесс олгох ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны нэрсийг хүргүүлсэн. Ажлын хэсэг байгуулагдсан. Гэсэн хэдий ч ажлын хэсгийн хуралдааныг зарлах ажлыг зохион байгуулаагүй, хүлээгдэж байна.	Зохион байгуулалтыг сайжруулах
3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.				
152	3.7.4. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих	70	Газрын нэгдмэл сангийн хөдөө аж ахуйн газрын бэлчээрийн ангиллын 6778 цэг, тариалангийн ангиллын газрын 100, хот суурин газрын ангиллын 300 цэг нийт 7178 цэгт судалгаа мониторингийн ажлыг улсын хэмжээнд гүйцэтгэн 2 журам, 3 аргачлалын төсөл боловсруулан, тухайн журам аргачлалын хүрээнд системийн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
153	3.7.5. Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	70	УБ хотын гэр хорооллын шугамд холбогдсон 180 орчим ус түгээх байрыг автоматжуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
154	3.7.6. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эхлүүлэх	70	Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 169 дүгээр тушаалын дагуу паркийн өргөтөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад шалгарсан "Өрх" ХХК 2021/47 дугаар гэрээний дагуу гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон магадлал хийлгэх ажлууд хийгдэж байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
155	3.7.2. Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах	50	"Геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах тухай" Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /нууцны зэрэглэлтэй/-ийг боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын гишүүдээс санал авч тусган, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгээд байна. Энэхүү хэлэлцээрийн төсөлд байр зүйн зураг зохиох чиглэлээр хоёр улсын холбогдох байгууллагууд хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг тусгасан.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
156	3.7.1. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	0	Шилний үйлдвэр нь стратегийн ач холбогдол бүхий хүнд үйлдвэр тул хамтран ажиллах тухай саналыг УУХУ-ийн сайдад 2022.10.12-ны өдрийн 1/4717 тоотгоор, Эдийн засаг, хөгжлийн сайдад 2022.10.12-ны өдрийн 1/4720 тоотгоор хүргүүлж, дэмжлэг хүсч, хамтран ажиллаж байна. Шилний үйлдвэрийн зураг төслийг урьдчилсан байдлаар 220 мянган ам.доллараар боловсруулж, батлуулсан. Хөгжлийн банканд хандан, шилний үйлдвэр байгуулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг удаа дараа хүргүүлсэн. Хөгжлийн банк энэ асуудлыг судалж үзээд, төслийн судалгааг зогсоосон тул Дэлхийн банкны олон улсын санхүүгийн корпорацад хүсэлт гарган төслөө судлуулж байгаа.	Санхүүжилтийг шийдвэрлэх, шийдвэр гаргалтыг хурдавчлах
4. Засаглалын бодлого				

4.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.				
157	4.1.1. Төрийн цахим үйлчилгээний e-mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээний төрөл, тоог нэмэгдүүлж хөгжүүлэх, иргэдэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах	77.5	Уг арга хэмжээний хүрэх түвшинг цахим системээр үйлчилгээ авах иргэдийн тоог 200000-аар нэмэгдүүлнэ гэж төлөвлөсөн бол хэрэгжилтэд үйлчилгээ авсан нийт иргэдийн тоо тодорхойгүй байгаа ба иргэд давхардсан тоогоор 19715313 удаа үйлчилгээ авсныг дурдсан байгаа нь хэрэгжилтийн хувийг аргачлалын 6.2.1-ийн дагуу үнэлэх боломжгүй байна. Иймд 6.2.2-ийн дагуу 70 хувиар үнэллээ. Төрийн байгууллагын үйлчилгээг нэгдсэн системд холбосон байдал Суурь түвшин - 50 Зорилтот түвшин - 70 Хүрсэн түвшин - 67 Хэрэгжилт = $(67-50)/(70-50)*100\%=85\%$ Дээрх 2 үйлчилгээний дундаж үнэлгээг тооцож үзвэл 77.5 хувь байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
158	4.1.2. Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформыг хөгжүүлж нэвтрүүлэх	90	ЗГ-ын 2020 оны 206-р тогтоолын 6.2.2.1.-д заасны дагуу зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч /Нэн шаардлагатай төрийн үйлчилгээний 5 системийг мэдэгдэл хүргэх нэгдсэн системд холбосон байна/ зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
159	4.1.5. "Нэг иргэн-Нэг бүртгэл" арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх	90	"Нэг иргэн-Нэг бүртгэл" хөтөлбөрийн үр нөлөөг үнэлж, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг гаргаж удирдлагад танилцуулсан. Нэг иргэн – Нэг бүртгэл үндэсний хөтөлбөрийн зорилт 3 "дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, иргэний бичиг баримтын үйлдвэрийг өргөтгөх;"- ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр иргэний үнэмлэхийн хэвлэх үйлдвэрийн 1 ш тоног төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд суурилуулалтын ажил бүрэн хийгдэж, ашиглалтад оруулсан.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
160	4.1.7. "Цахим архив албан хэрэг хөтлөлт" арга хэмжээний төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах, архивын нэгжийн цахимжуулалтыг эрчимжүүлэх	90	Суурь түвшин - Боловсруулсан төслийн тоо 0, цахимжуулсан архивийн нэгжийн тоо 53000 Зорилтот түвшин - Боловсруулсан төслийн тоо 1, цахимжуулсан архивийн нэгжийн тоо 100000 Хүрсэн түвшин - Боловсруулсан төслийн тоо 1, цахимжуулсан архивийн нэгжийн тоо 23210 Боловсруулсан төслийн тоо хэрэгжилт = $(1-0)/(1-0)*100\%=100\%$ Цахимжуулсан архивын нэгж Хэрэгжилт = $(23210-53000)/(100000-53000)*100\%=63.4\%$ Дундаж үнэлгээ $(100\%+63.4\%)/2= 81.7\%$	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
161	4.1.13. Хүн ам олноор суурьшсан, аялал жуучлалын бүс нутгуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох	70	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нэг аймгийн нэг багт 60км урт шилэн кабель, 3500 амжиргааны түвшин доогуур өрхөд суурин интернет үйлчилгээгээ хүргэх зорилгоор 154 км урт шилэн кабель тус тус суурилуулж өндөр хурдны өргөн зурвасын суурин интернет сүлжээг байгуулсан. Мөн алслагдсан 238 багт үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлсэн ба нийт 300 мянга орчим иргэн өндөр хурдны хөдөлгөөнт интернетэд холбогдох, мэдээ, мэдээлэл шуурхай авах, аялагч амрагчид харилцаа холбооны бусад үйлчилгээг саадгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлсэн.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
162	4.1.6. Тоон бичиг үсэгтэн болгох сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулж, түгээх	50	Хүрэх түвшин буюу зорилтот түвшний үзүүлэлтийг иргэдийн технологи ашиглах чадварыг 50 хувьд хүргэнэ гэж тодорхойлсон боловч хэрэгжилтэд 21626 иргэнийг Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх сургалтад хамруулж, 3 түвшний сургалтын хөтөлбөр боловсруулахаар ажиллаж байна. Үүнээс үзэхэд Монгол Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах иргэдийн чадварын түвшин 50 хувьд хүрсэн эсэх нь хэрэгжилтэд дурдсан тоон үзүүлэлтүүдээр илэрхийлэгдэхгүй байна. Суурь түвшин - 32% Зорилтот түвшин - 50% Хүрсэн түвшин - Тодорхойгүй учраас ЗГ-ын 206-р тогтоолын 6.2.2.3-ийг үндэслэл болгон 50 хувиар үнэлэв.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
163	4.1.11. Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим системийг хөгжүүлэх	70	Албан бичиг солилцооны дундын системд 2022 оны 12 дүгээр сарын 22-ний өдрийн байдлаар 4302 байгууллагын ашиглалдаг 15 систем холбогдсон бөгөөд нийт 8116 бичиг солилцсон байна.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
164	4.1.17. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	70	1.Шуудангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасны дагуу "Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журам"-ын төслийг боловсруулах, шуудангийн үндсэн сүлжээний өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, ажиллах удирдамжийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж, улс хоорондын болон дотоодын шуудан, ачаа тээврийн өнөөгийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл солилцож, журмын төслийг боловсруулах үндэслэлийг танилцуулсан. Мөн Монгол Улсын 21 аймаг, 30 сумдын Засаг даргын Тамгын газраас шуудангийн үйлчилгээний талаарх судалгааг авч нэгтгэсэн ба шуудангийн үндсэн сүлжээний эзэмшигчийн орлого, зарлагын шинжилгээг хийж, олон улсын туршлагаас судалсны дүнд журмын төслийг эхний байдлаар боловсруулан, ажлын хэсгийн гишүүдээс санал авсан.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
165	4.1.19. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	70	Компанийн засаглалын ОУ-ын туршлагыг судлах, нэвтрүүлэх хүрээнд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, МУ-д нэвтрүүлэх, тус улсын Темасек холдинг корпорацитай холбох асуудлаар яриа хэлцэлийн дагуу тус байгууллагатай цахимаар холбогдох бэлтгэл ажлыг хангах, санал солилцох чиглэлээр ажиллав. Төрийн өмчит 9 компанид хийсэн компанийн засаглалын 2022 оны үнэлгээ дунджаар 69.0 хувьтай байна.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
166	4.1.9. Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгох	30	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайд нарын 2022 оны А/260, А/391, А/146, А/260 дугаар хамтарсан тушаалаар "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)"-г баталсан. Уг төлөвлөгөөнд "Ахисан түвшний сургалт"-ын хөтөлбөрт кибер аюулгүй байдлын талаар багц сургалтын хөтөлбөр бэлтгэхээр тусгасан.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

167	4.1.10. Нэгдүгээр ээлжийн тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авч, Цахим мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын нэгдсэн төв /үндэсний CERT/-ийн үйл ажиллагааг эхлүүлэх	30	Америкийн Нэгдсэн Улсын Карнеги Меллоны Их Сургуультай хамтын ажиллагааны хүрээнд Кибер аюулгүй байдлын боловсон хүчин чадварыг дээшлүүлэхээр "Компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх баг байгуулах" сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 22-ноос 25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 20 байгууллагын 34 албан хаагч хамрагдсан. Санхүүжилтгүйн улмаас тоног төхөөрөмжийн худалдан авалт удаашралтай байна.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
168	4.1.12. Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох /Дорнод аймгийн Дашбалбар, Чулуунхороот, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх/	50	2022 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл" -ийн хүрээнд Дорнод аймгийн Дашбалбар сум, Чулуунхороот сум, Төв аймгийн Мөнгөнморьт, Баян-Өнжүүл, Дундговь аймгийн Баянжаргалан, Хөвсгөл аймгийн Ханх зэрэг 6 сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажил хийгдэнэ. Энэхүү ажил хийгдэж дууссанаар Монгол Улсын 330 сум бүгд шилэн кабелийн сүлжээнд холбогдож дуусахаар байна.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
169	4.1.18. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах	50	Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын шилдэг программ хангамж үйлдвэрлэгч болон стартап компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг Төв азийн бүс нутгийн улсууд болох Узбекистан, Казакстан, Киргиз, Туркменистан, Тажикстан зэрэг орнуудад сурталчлах, мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг нэмэгдүүлэх, стартап компаниудыг бизнесээ тогтвортой эрхэлж, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/738 дугаар албан бичгийг аяллын төлөвлөгөө болон 7 компанийн танилцуулгын хамт Гадаад харилцааны яаманд хүргүүлж хамтран ажилласан. 3.ХХМТ-ийн салбарын инновацийн эко системийг бүрдүүлэх, мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөний төсөл боловсруулсан.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
170	4.1.4. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн санд холбох	0	Мэдээллийн нэгдсэн санд холбох бэлтгэл ажлуудыг авч эхэлж байгаа.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
171	4.1.15. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг байгуулах	30	Газрын тухай хууль болон Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Барилга хот байгуулалтын яаманд 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1319 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хуулийн төслийг байнгын хороодоор хэлэлцүүлэх ажлыг Барилга, хот байгуулалтын яамаас зохион байгуулж байна. Дээрх хуулиудад өөрчлөлт орсноор харилцаа холбооны дэд бүтцийн бүтээн байгуулалт нь бусад инженерийн дэд бүтэцтэй уялдах юм. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ний А/76 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд Тоон радиогийн ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулсан. Мөн 2023 оны улсын төсвийн төсөөлд тусгуулахаар санал хүргүүлсэн.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, шийдвэр гаргалтыг хурдасгах
172	4.1.16. Худаг сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах	30	Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн худаг сувагчлалын зураглалын дагуу чөлөөлөх шаардлагатай зэс кабель, шинээр татах шилэн кабелийн тооцоог гаргаж, санал боловсруулан 2023 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн хязгаарын саналд суулиулан Сангийн яаманд хүргүүлсэн. Энэ ажилд "Мэдээлэл холбооны сүлжээ" Хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Монголын цахилгаан холбоо" Хувьцаат компани хамтран оролцож байгаа бөгөөд одоогоор "Мэдээлэл холбооны сүлжээ" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ажил эхэлж хотын төв зам дагуу Наран станцаас зүүн тийш Офицеруудын ордон чиглэлд, КШ-32 оор Бага тойругаас их тойруу чиглэлд, КШ-68 аар, КШ-45 чиглэлд нийт 54,769 м кабель чөлөөлөх ажил явагдаж байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
4.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.				
173	4.2.1. Ёс зүйн болон сахилгын зөрчлийн талаарх нэгдсэн бүртгэлийн системийг бий болгох	70	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын модуль хөгжүүлэлтийн ажил дууссан бөгөөд систем нэвтрүүлэх хүрээнд төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн бүртгэлийн ажил хийгдэж байна. Бүртгэлийн систем бүрэн хөтлөгдөөгүй.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
174	4.2.3. Яамдын жөндөрийн салбар зөвлөлийн жөндөрийн бодлогын хэрэгжилтийг хангах	70	Нийт 12 салбарт хэрэгжиж байгаа бодлогын хэрэгжилтийг үнэлж үзэхэд дунджаар 40 хувийн хэрэгжилттэй байна. Эрчим хүч, соёл болон цахим хөгжил, харилцаа холбооны салбарт жөндөрийн бодлого стратеги боловсруулах ажлын хэсгүүд байгуулагдаж, оролцоонд суурилсан жөндөрийн үнэлгээ хийх суурь судалгааны ажил эхэлсэн.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
175	4.2.4. Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд жөндөрийн бодлогын хэрэгжилтийг хангах	70	Жөндөрийн салбар хороо 21 аймаг, нийслэл, 8 дүүрэг жөндөрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг батлуулан ажиллаж байна. Холбогдох жөндөрийн салбар хорооноос ирүүлсэн дэд хөтөлбөр, арга хэмжээний 2021 оны хэрэгжилт (дундаж) 80.6 хувьтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
176	4.2.2. Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулах	30	Зураг төсвийг батлуулж, Удирдлагын академийн сонсогчдын дотуур байр, дэмжих үйлчилгээний төвийн шинэ барилга баригдаж эхэлсэн бөгөөд 2021 онд 500 сая, 2022 онд 2.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
4.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.				
177	4.3.6. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум дахь хилийн 0243 дугаар английн нэгдсэн цогц барилгын ажлыг дуусгах /нийт 8 барилга байгууламж/	90	Зорилгот түвшинг шинээр ашиглалтад оруулах барилгын тоо 5 гэж төлөвлөсөн, хэрэгжилтээс харахад зарим барилга байгууламжийн суурь, 1, 2 дугаар давхрын карказ зангидаж, цутгалт хийж дууссаныг барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь гэж үнэлсэн нь учир дутагдалтай байна. Мөн улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ төлөвлөснөөс бага байгаа нь ажлын гүйцэтгэл дутуу байгааг илэрхийлж байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
178	4.3.7. Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийг шинэчлэх	90	Зорилгот түвшинг төлөвлөсөн арга хэмжээнд тусгагдаагүй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр төсөвт өртөгийг хэтрүүлсэн байна. Тухайлбал 4 км хамгаалалтын хашаа барихаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 13.1 км хашаа барьсан г.м	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
179	4.3.10. Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, стратегийн орд, ус хангамжийн эх үүсвэрийн объектыг хамгаалалтад авах	90	Хүрэх түвшинд 7 объектийг хүлээн авахаар төлөвлөснөөс нийт 6 объектыг Дотоодын цэргийн хамгаалалтад авсан. Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг 2023 онд дотоодын цэргийн хамгаалалтад авахад шаардагдах орон тоо, зардлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

180	4.3.11. Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэний хурууны хээ, био мэдээллийн сангаас мэдээлэл унших, оршин суух үнэмлэх олгох системийг хөгжүүлэх, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбох	70	"Ажлын хэсэг"-ээс "Гадаадын иргэний оршин суух бүртгэл, хяналт, үнэмлэх хэвлэх программ хангамжийн ажил гүйцэтгэх" 01/10-74 дүгээр гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд үнэлгээ хийж, гэрээний хавсралтад заасан ажлын даалгаврын дагуу программ хангамжийг хүлээн авснаар санхүүжилтийг 100 хувь олгож, тус программ хангамжийг туршилтаар нэвтрүүлээд байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
181	4.3.13. Хоригдлыг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх тогтолцоог орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх	70	Хоригдлыг суллагдахад бэлтгэх зорилгоор 417, 419, 439 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиуд нь тусгайлан нийгэмшүүлэх байр болон өрөөг бэлтгэн тохижуулж, нийгмийн харилцаа, амьдралд гарахад бэлтгэх, дэдлага олгох сургалтыг зохион байгуулж байна. "Дахин гэм хэрэг үйлдсэн хоригдлуудын харилцааны түвшинг нийгэмшүүлэх үйл ажиллагаатай холбон судлах" судалгааны ажлын гарын авлагын эхийг бэлтгэн, хэвлүүлэхэд бэлэн болгосон нь тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа байдалтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
182	4.3.17. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх /Улаанбаатар хот, орон нутгийн бүх камер/	70	Тайлбар, уг арга хэмжээний хүрэх түвшинг 60 цэгт дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэхээр төлөвлөснөөс 13 постод суурилуулсан нь аргачлалын дагуу үнэлэхэд 20 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
183	4.3.19. Хилийн заставуудын барилга объектуудын шинэчлэл хийх	70	Хилийн заставуудын барилга объектуудын шинэчлэл хийх шалгуур үзүүлэлттэй уг арга хэмжээний хүрэх түвшин гүйцэтгэл 40 хувьд хүрсэн байхаар төлөвлөсөн. Хэрэгжилтийн байдлаас харахад 34 айлын нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны системтэй орон сууц-хилийн цэргийн 7 ангид, ердийн галлагаатай 20 айлын орон сууц-5 салбарт, 2 ангид гэрээт цэргийн байр шинээр барьсан, 2 ангийн 9 салбарын гэрээт цэргийн байранд засвар хийж, ашиглалтад оруулсан нь хүрэх түвшинд хүрсэн эсэхийг үнэлж тодруулахад уялдаагүй төлөвлөгдсөн байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
184	4.3.20. Хилийн заставын авто паркийн шинэчлэл хийх	70	Хэдэн ширхэг автомашинаар хангаж байж гүйцэтгэл 100 хувьд хүрэхийг шалгуур үзүүлэлт, хүрэх зорилтот түвшинд уялдуулаагүй төлөвлөсөн байна. Иймд ЗГ-ын 206-р тогтоолын 6.2.2.3-ийг үндэслэл болгон 50 хувиар үнэлэв.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
185	4.3.21. Хилийн боомтын нэвтрүүлэх үйл ажиллагаанд ухаалаг гарцын систем нэвтрүүлэх	70	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа гэж үзэн үнэлгээг бууруулсан. Тухайлбал, "Чингис хаан" боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, агаарын тээврийг хялбаршуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөл суурилсан цахим гарц 8, зорчигчийн гар тээш шалгах рентген төхөөрөмж 2-ыг тус худалдан авч, суурилуулахад шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан. БНСУ-ын цахим гарцын төхөөрөмж үйлдвэрлэгч "Cubox" компанитай уулзалт зохион байгуулж, техникийн шийдлийг судалж байгаа явцтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
186	4.3.8. Хилийн 10 салбарыг төвлөрсөн эрчим хүчинд холбох	50	Шинээр төвлөрсөн эрчим хүчинд холбох салбарын тоог 10 гэж төлөвлөсөн боловч хэрэгжилтэд бүрэн холбогдсон 2 салбар, бүрэн холбогдоогүй 2 салбар, 5 салбарт 5 кВт-ын сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр шинээр угсарч ашиглалтад оруулсныг дурджээ. Иймд ЗГ-ын 206-р тогтоолын 6.2.1-д зааснаар үнэлэх боломжгүй гэж үзэн 6.2.2.3-ийг үндэслэн 50 хувиар үнэллээ.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
187	4.3.14. Криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах	50	Төндөр шалгаруулах урилгыг хүргүүлэх шатанд үргэлжилж байгаа тул тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байна гэж дүгнэсэн.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
188	4.3.16. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлэхийн тулд лабораторийн 350 багаж, тоног төхөөрөмж авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулах	50	Тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэснээр хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн хэдэн хувийг тодорхойлох хүчин чадалтай болсон талаар шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан. БНСУ-ын цахим гарцын төхөөрөмж үйлдвэрлэгч "Cubox" компанитай уулзалт зохион байгуулж, техникийн шийдлийг судалж байгаа явцтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
189	4.3.9. Хилийн 4 боомтыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх	30	Шинээр нэгдсэн системд холбох боомтын тоо - 4 гэж хүрэх түвшинг тодорхойлсон бол хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлэхэд Суурь түвшин - 3 боомт Зорилтот түвшин - 4 боомт Хүрсэн түвшин - 0 боомт Хэрэгжилт = $(0-3)/(4-3)*100\% = 0$	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
190	4.3.12. Нийслэл, 21 аймгийн онцгой байдлын шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийг байгуулж, нэгдсэн системд холбох; "Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" зээлийн төсөл хэрэгжүүлж эхлэх	30	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа гэж үзэв. Тухайлбал, арга хэмжээний хэрэгжилтийн явц "Монгол Улсад гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь" зээлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн ерөнхий загвар, төслийн удирдлагын гарын авлага, техникийн тодорхойлолтууд болон холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулсан, төслийг 2023 онд хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Шадар сайдаар уламжуулахаар 2022.11.25-ны өдрийн 1/2479 дугаар бичгээр Монгол Улсын Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд хүсэлт хүргүүлсэн байдалтай байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
191	4.3.18. Ус, цаг уурын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, чадавхыг бэхжүүлэх	30	Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал 2022 оны Монгол улсын төсөвт тусгагдаагүй, гадаад хамтын ажиллагааны хүрээнд Бүгд найрамдах Солонгос улсын Цаг уурын байгууллагад цаг уурын автомат станц суурилуулах төсөл хэрэгжүүлэх санал тавьсаны дагуу БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2023 онд 20 ш автомат станц Өвөрхангай, Дундговь аймгуудад суурилуулах төсөл хэрэгжүүлэх болсныг албан бичгээр мэдэгдсэн. энэ ажлын хүрээнд 2022 оны 8 болон 11-р сард Солонгосын цаг уурын байгууллагын мэргэжилтнүүд Монгол улсад ирж төслийн урьдчилсан судалгаа хийсэн бөгөөд төсөл хэрэгжихэд бэлэн болсон.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

192	4.3.15. Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлэх	0	Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангах төсөв батлагдаагүй болно.	Санхүүжилтийг шийдвэрлэх
4.4. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.				
193	4.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих	90	Улсын үзлэг, тооллогын мэдээллийн системийн техник болон программ хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд нийт 29.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж, бүртгэл, дүн мэдээг нэгтгэх боломжийг бүрдүүлснээр төрийн болон орон нутгийн өмчит 6613 хуулийн этгээдийн улсын үзлэг, тооллогын дүн мэдээг хянан баталгаажуулах ажлыг хийж дууссан.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
4.5. Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.				
194	4.5.3. Хилийн чанад дахь иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, цахим үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэх	90	Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлсэн байна.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
195	4.5.1. "Дэлхийн Монголчууд II" цогц арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх	70	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 70-аас дээш хувьтай хэрэгжүүлсэн байна гэж зорилтот түвшинг төлөвлөсөн боловч ямар ямар шалгуурыг хангасан тохиолдолд 70 хувь нь хэрэгжсэн байх нь тодорхойгүй тул 50 хувь хэрэгжилттэй гэж үнэллээ. Тухайлбал, Дэлхийн Монголчууд - 2 цогц арга хэмжээний хүрээнд 7 зорилт дэвшүүлж, 97 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 56 арга хэмжээ 100 хувь, 5 арга хэмжээ 90 хувь, 7 арга хэмжээ 70 хувь, 10 арга хэмжээ 50 хувь, 9 арга хэмжээ 30 хувийн гүйцэтгэлтэй байна гэснээс үзэхэд 87 арга хэмжээ 30-100 хувийн хэрэгжилттэй байна. Огт хэрэгжээгүй 10 арга хэмжээ, 50-иас доош хувийн гүйцэтгэлтэй 19 арга хэмжээ байна гэж үзвэл нийт 29 арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байгаа тул 50 хувь гэж үнэлэв.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
196	4.5.2. Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх	50	Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг төлөвлөсөн боловч хэрэгжилт нь хангалтгүй байгаа тул ЗГ-ын 206-р тогтоолын 6.2.2.4-ийн дагуу 30 хувиар үнэлсэн. Үүнд: 1) хилийн чанадад төрж, гадаад улсын харьяат болсон монгол хүн эх орондоо зорчих, оршин суух таатай нөхцлийг бүрдүүлнэ; 2) гадаадын харьяат монгол хүн Монгол Улсын иргэншил авах, сэргээн тогтоолгох процедурыг хялбаршуулна; 3) нийгмийн хамгааллын салбарт хоёр талын хэлэлцээр байгуулж, хилийн чанадад хөдөлмөр эрхэлдэг иргэд хоёр улсаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг бүрдүүлэх нөхцлийг эрэлхийлнэ; 4) гадаадаас мөнгө гуйвуулах өртгийг багасгах чиглэлээр банкуудтай яриа хэлцэл хийж тодорхой тохиролцоонд хүрнэ; 5) гадаадын цагаачдыг эх орондоо жижиг, дунд үйлдвэр байгуулахад зориулж санхүүгийн дэмжлэг үзүүлдэг Нидерланд зэрэг орны "IntEnt" төслүүд, НҮБ-ын хөгжлийн "ТОКТЕН" зэрэг хөтөлбөрт хилийн чанад дахь иргэдээ хамруулахад туслалцаа үзүүлнэ зэрэг арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
4.6. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.				
197	4.6.4. Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, технологи, инновацыг нэвтрүүлэх замаар батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн эхлэлийг тавих	90	Уг төсөл арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох хуулийн хүрээнд мэдээлэх боломжгүй гэх байдалд 50 хувиар үнэлсэн нь бодитой бус үнэлгээ байна. Үнэлэх боломжгүй гэж дүгнэв.	
198	4.6.5. Кибер аюулгүй байдлын төвийн чадавхыг дээшлүүлэх	70	Уг төсөл арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох хуулийн хүрээнд мэдээлэх боломжгүй гэх байдалд 50 хувиар үнэлсэн нь бодитой бус үнэлгээ байна. Үнэлэх боломжгүй гэж дүгнэв.	
199	4.6.2. Цэргийн II шатны эмнэлгийг байгуулах бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	50	Уг төсөл арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох хуулийн хүрээнд мэдээлэх боломжгүй гэх байдалд 50 хувиар үнэлсэн нь бодитой бус үнэлгээ байна. Үнэлэх боломжгүй гэж дүгнэв.	
5. Ногоон хөгжлийн бодлого				
5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.				
200	5.1.13. Химийн хорт болон аюултай бодисын цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох	90	Гадаадын зээл тусламжийн төсөвлөсөн хөрөнгийн санхүүжилт хийгдээгүй.	Төлөвлөлт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
201	5.1.18. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлэх	90	Зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
202	5.1.1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	30	Төндөр шалгаруулалт үргэлжилж, бэлтгэл ажил дуусаагүй.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
203	5.1.2. Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж байгуулах ажлын бэлтгэл хангах	50	Байгууламж барих газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, концессийн зүйлийн жагсаалтад өөрчлөлт оруулах зэрэг бэлтгэл ажил хийгдсэн ч зарлах эрхийг өөр яам харьяалагддаг гэсэн үндэслэлээр арга хэмжээний хэрэгжилт хойшлогдсон.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
204	5.1.5. Томоохон хот, суурин газруудад агаарын чанарыг 5-аас доошгүй үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлэх	50	Агаарын чанарыг хянах хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн ч 6 аймаг агаарын чанарыг 2 үзүүлэлтээр хянах боломжийг бүрдүүлсэн, зорилтот түвшинд заасан аймгуудыг бүрэн хамруулаагүй, 10000 дээш хүн амтай төв суурин газар агаарын чанарыг хянах ажил төндөрийн маргаантай холбоотой зогссон байна.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
205	5.1.6. Хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлэх	70	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ч төсвийн тодотголоор хасагдсан.	Санхүүжилтийг шийдвэрлэх

206	5.1.7. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбох	70	Санхүүжилт дутуу	Санхүүжилтийг шийдвэрлэх
207	5.1.11. Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, хадгалах арга хэмжээг хэрэгжүүлэх	50	Ажлын хариуцлага, удирдлага, зохион байгуулалт сул, төлөвлөлтийн үндэслэл тооцоо дутуу	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
208	5.1.12. Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны тархац нөөцийг тогтоох	70	Ажлын хариуцлага, удирдлага, зохион байгуулалт сул	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
209	5.1.15. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарт хэрэгжүүлэх	70	Санхүүжилт байхгүй.	Санхүүжилтийг шийдвэрлэх
210	5.1.19. Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгааг хийж, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх	50	Үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдал	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
211	5.1.20. Бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах	61	Улз гол дээр баригдах шороон боомт Монголын дархан цаазат газарт хамаарч байсан тул UNESCO-ын шаардлагаар байгаль орчны нарийвчилсан судалгаа хийсэн. Төлөвлөлтийн үндэслэл тооцоо дутуугаас Улз голын урсацыг нэмэгдүүлэх шороон боомтын ажил эхлээгүй байна.	Төлөвлөлтийг оновчтой болгох
212	5.1.17. Хөвсгөл нуурт живсэн машин, техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах	30	Уулзалт, хэлэлцүүлгийн түвшинд ажил хийгдсэн нь удирдлага, зохион байгуулалт, түншлэгч байгууллага хороондын идэвхтэй хамтын ажиллагаа сул, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг муу	Төлөвлөлтийг оновчтой болгох, Санхүүжилтийг шийдвэрлэх, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
213	5.1.3. Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлэх	30	Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн дуусаагүй байгаа нь хөрөнгө нөөцийн дутагдал, ажлын зохион байгуулалттай холбоотой.	Төлөвлөлтийг оновчтой болгох, Санхүүжилтийг шийдвэрлэх, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
214	5.1.4. Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын системийг сайжруулах, усан халаалтын зуухны түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар халах, инженерийн дэд бүтцийн бичил төвүүдийг байгуулах, Евро 5 ангиллын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх, цахилгаан хөдөлгүүртэй автобусаар нийтийн тээврийн парк шинэчлэл хийх зэрэг агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	30	Гүйцэтгэл дунджаар 70.2 хувьтай гэж тайлагнасан ч Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламжийг 50 мкг/м3 хүргэх зорилт гүйцэтгэлээр 97мкг/м3, PM10 тоосонцрын агууламжийг 107 мкг/м3-д хүргэх зорилт гүйцэтгэлээр 119мкг/м3 гарч шалгуур үзүүлэлтээ хангаагүй буурсан байгаа нь үйл ажиллагаа оновчтой бус байна.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
215	5.1.14. Туул голын хамгаалалтын бүсэд орших түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, аж ахуйн нэгжээр нөхөн сэргээлт хийлгэх	30	Ажлын хариуцлага, удирдлага, зохион байгуулалт сул	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
216	5.1.16. Байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг дэмжих ногоон зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж, 1000-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг үг зээлд хамруулах	70	2022 оны байдлаар нийт 400 гаруй иргэн, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Хүрэх түвшин 1000-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг үг зээлд хамруулахаар төлөвлөсөн байсан.	Төлөвлөлт, Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
217	5.1.8. Цаг уурын бодит болон цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэргэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх	0	Эх үүсвэрийг шийдвэрлээгүй.	Санхүүжилтийг шийдвэрлэх
6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого				
6.1. Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.				
218	6.1.1. "Дэнжийн мянга дэд төв", "Дамбадаржаа дэд төв" төслийг хэрэгжүүлэх	90	Үйл ажиллагаа, зохион байгуулалтын байдал	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
219	6.1.5. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх	70	Улирлаас хамаарч барилгын ажил зогссон.	Төлөвлөлтийг оновчтой болгох
220	6.1.6. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30000 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	70	Үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдал	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
221	6.1.7. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	90	Үерийн 1.7 км далан /Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/: Төсөвт өртөг - 2,6 тэрбум төгрөг. Барилга угсралтын ажил 100 хувь; 3.Хайлаастын /Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/ авто замын ус зайлуулах 1.5 км цутгамал төмөр бетон сувгийн барилга угсралтын ажил 100 хувь хийгдэж ашиглалтад оруулсан.	Төлөвлөлтийг оновчтой болгох
222	6.1.13. "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх	70	Хэсэгчилсэн төлөвлөгөөг батлуулаагүй, боловсруулах шатандаа байгаа нь үйл ажиллагаа, зохион байгуулалт, шуурхай байдал сул	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах

223	6.1.12. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	50	Зохион байгуулалтын үйл ажиллагааны шуурхай байдал сул. 2022 ны 3 дугаар улиралд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
224	6.1.9. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	30	Багц 12 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч үр дүн бага, түгжрэлийг 15 хувь бууруулах зорилгот түвшиндээ хүрээгүй нь удирдлага зохион байгуулалтын оновчтой, шуурхай байдал сул	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
225	6.1.10. Улаанбаатар хотод олон улсын логистикийн төв байгуулах	30	Төв байгуулагдаагүй ба төслийг ТХХТ ээр хэрэгжүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлжээ. Улсын төсвөөс шаардлагатай санхүүжилт хийгдээгүй, улмаар ТХХТ-ээр хэрэгжүүлэх зохицуулалт хийсэн нь анхнаас төсөвлөлт оновчтой бус байна.	Төлөвлөлтийг оновчтой болгох, Санхүүжилтийг шийдвэрлэх
6.2. Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.				
226	6.2.4. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/	90	Төсөвлөсөн гадаад зээл тусламжийн эх үүсвэр бүрэн олгогдоогүй	Төлөвлөлтийг оновчтой болгох, Санхүүжилтийг шийдвэрлэх
227	6.2.5. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай эхлүүлэх	90	Төсөвлөсөн эх үүсвэр бүрэн олгогдоогүй.	Төлөвлөлтийг оновчтой болгох, Санхүүжилтийг шийдвэрлэх
228	6.2.7. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулах	90	Орон нутгийн төсвөөс төсөвлөсөн санхүүжилт гараагүй.	Санхүүжилтийг шийдвэрлэх
229	6.2.9. "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах	90	Улсын төсвөөс төсөвлөсөн хөрөнгийн санхүүжилт дутуу	Төлөвлөлтийг оновчтой болгох
230	6.2.2. 10 аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчилж, шинээр барих	70	Санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоолоогүй	Төлөвлөлтийг оновчтой болгох
231	6.2.1. 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барих /Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв/	50	Тендерийн маргаантай холбоотой шүүхээс төслийн ажлыг түр зогсоох шийдвэр гарсан.	Үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах
232	6.2.11. Хангайн бүсийн төв Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын зарим орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах /Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх, Уянга, Бат-Өлзий сумдыг "Сумын хөгжил" арга хэмжээнд хамруулах/	70	Улсын төсөв, гадаад зээл, тусламжийн төсөвлөсөн санхүүжилт дутуу	Санхүүжилтийг шийдвэрлэх